



МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

**ЗАСГИЙН ГАЗРЫН 2019 ОНЫ САНХҮҮГИЙН
НЭГТГЭСЭН ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН
ТАЙЛАН**

Улаанбаатар хот

2020 оны 6 дугаар сар



АГУУЛГА

Тайлан бэлтгэсэн:	Товчилсон үгийн жагсаалт	2
Санхүүгийн аудитын газар	Аудитын гэрчилгээ	3
	Аудит хийсэн Засгийн газрын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан	5
Газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор:	Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан	5
	Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан	6
Ц.Наранчимэг	Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	7
	Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан	8
Аудитын менежер:	Аудитын талаарх үндсэн мэдээлэл	10
	Санхүүгийн тайланг нэгтгэхэд баримталсан аргачлал, зарчим	12
Г.Гүнжидмаа	Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн талаар	14
	Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн тодруулга, аудитын дүн	15
Ц.Хосжаргал	Нэг. Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	15
	1.1 Мөнгөн хөрөнгө	15
Ахлах аудитор:	1.1 Төв төрийн сангийн мөнгөн хөрөнгө	15
	1.2 Нийгмийн даатгалын сангийн мөнгөн хөрөнгө	16
Б.Сэржмядаг	1.3 Эрүүл мэндийн даатгалын сангийн мөнгөн хөрөнгө	16
	1.4 Төсвийн ерөнхийлөн захирагчдын мөнгөн хөрөнгө	17
П.Чанцалдулам	Хоёр. Богино хугацаат хөрөнгө оруулалт	18
	Гурав. Авлага	19
Ж.Болормаа	3.1. Авлага	19
	3.2 Төрийн сангийн авлага	19
Р.Цолмон	3.3 Гадаад зээлээс дамжуулан зээлдүүлсэн зээлийн авлага	20
	3.3 Төсөвт байгууллагын авлага	21
Аудитор:	3.4 Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн авлага	22
	3.5 Нийгмийн даатгалын сангийн авлага	22
Ц.Цэрэнхүү	3.6 Эрүүл мэндийн даатгалын сангийн авлага	22
	Дөрөв. Урьдчилгаа	23
С.Бат-Эрдэнэ	Тав. Бараа материал	24
	Зургаа. Бусад эргэлтийн хөрөнгө	24
А.Даваадорж	Долоо. Урт хугацаат хөрөнгө оруулалт	25
	Найм. Үндсэн хөрөнгө	26
П.Амарсанаа	8.1 Үндсэн хөрөнгө	26
	8.2 Дуусаагүй барилга, байгууламж	27
Э.Энхбаатар	Ес. Өр төлбөр	27
	9.1 Нийт өр төлбөр	27
Ч.Дашдаваа	9.2 Үнэт цаас, зээлийн өглөг	28
	9.3 Засгийн газрын үнэт цаас, зээл	28
Л.Мөнхцацрал	9.4 Төрийн өмчит хуулийн этгээдийн өр төлбөр	29
	9.5 Төсөвт байгууллагын өр төлбөр	29
Г.Мөнхчимэг	9.6 Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдын төлбөр	30
	9.7 НДС, ЭМДС-ийн өр төлбөр	30
Д.Болор-Эрдэнэ	Арав. Засгийн газрын хувь оролцоо	31
	10.1 Засгийн газрын хувь оролцоо	31
Г.Түвшинзаяа	10.2 Төрийн өмчийн хувь оролцоо	31
	10.3 Орон нутгийн өмчийн хувь оролцоо	31
2020 оны 6 дугаар сар Уг тайланг УАГ-ын Цахим хуудаснаас үзнэ үү: www.audit.mn	Арван нэг. ТЕЗ-дын санхүүгийн тайланд хийсэн аудитын дүн	32
Аудитын тайлантай холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 261663 дугаарын утсаар харилцана уу.	11.1 УТЕЗ-дын санхүүгийн тайлангийн аудит	32
	11.2 ОНТЕЗ-дын санхүүгийн тайлангийн аудит	32
ХАЯГ:	11.3 Төрийн өмчит хуулийн этгээдийн санхүүгийн тайлангийн аудит	32
	11.4 Засгийн газрын зээл, тусламжаар хэрэгжиж буй төслүүдийн санхүүгийн тайлангийн аудит	33
Үндэсний аудитын газар Засгийн газрын IV байр, Бага тойруу-6, Улаанбаатар-46 Монгол Улс	11.5 Засгийн газрын тусгай сангуудын санхүүгийн тайлангийн аудит	34
Арав хоёр. Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар илэрсэн зөрчил	Арван гурав. Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт	35
	Арван дөрөв. Дотоод аудит	36
Арван тав. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	Дүгнэлт	36
	Аудитын зөвлөмж	37
	Аудитын тайланг баталгаажуулсан тушаал	39



Товчилсон үгийн жагсаалт

ААНБ	Аж ахуйн нэгж, байгууллага
ААТҮГ	Аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
АЗЗА	Авто зам, засвар арчлалт
АОУС	Аудитын олон улсын стандарт
БОАЖЯ	Байгаль орчин, аялал жуулчлалын яам
БХБЯ	Барилга, хот байгуулалтын яам
БХЯ	Батлан хамгаалах яам
БСШУСЯ	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам
БСШУСС	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд
ГХЯ	Гадаад харилцааны яам
ДОХ	Дархлалын олдмол хомсдол
ЕТГ	Ерөнхийлөгчийн Тамгын газар
ДЦС	Дулааны цахилгаан станц
ЕС	Ерөнхий сайд
ЖДҮХС	Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан
ЗГХЭГ	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар
ЗГСНТ	Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан
ЗТХЯ	Зам, тээврийн хөгжлийн яам
ЗТХС	Зам, тээврийн хөгжлийн сайд
ЗГ	Засгийн газар
ИНЕГ	Иргэний нисэхийн ерөнхий газар
МИАТ	Монголын иргэний агаарын тээвэр
НДҮЗ	Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл
НББ	Нягтлан бодох бүртгэл
НДС	Нийгмийн даатгалын сан
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
ОНӨҮГ	Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар
ОНТЭЗ	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагч
ОУВС	Олон улсын валютын сан
СБД	Сүхбаатар дүүрэг
СТОУС	Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт
ТЭЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТОСК	Төрийн орон сууцны корпорац
ТӨААТҮГ	Төрийн өмчит, аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ТЭДС	Тариалан эрхлэлтийг дэмжих сан
УУХҮЯ	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам
УУХҮС	Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд
УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
УТЭЗ	Улсын төсвийн ерөнхийлөн захирагч
УТҮГ	Улсын төсөвт үйлдвэрийн газар
ХЗДХЯ	Хууль зүй, дотоод хэргийн яам
ХК	Хувьцаат компани
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХНХЯ	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
ХНХС	Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд
ХХААХҮЯ	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
ШС	Шадар сайд
ЭХЯ	Эрчим хүчний яам
ЭМДС	Эрүүл мэндийн даатгалын сан
ЭМҮЗ	Эрүүл мэндийн үндэсний зөвлөл
ЭМЯ	Эрүүл мэндийн яам



**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД
УХНААГИЙН ХҮРЭЛСҮХ ТАНАА

2020.06.10 № 2465
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.10.2-т заасны дагуу Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайланд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Хязгаарлалттай дүгнэлт

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайланг УСНББОУС, СТОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан заавар, аргачлал, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв илэрхийлсэн тул хязгаарлалттай санал дүгнэлт өгч байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам”-ын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн нэгтгэсэн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Монгол Улсын Засгийн газрын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгад дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.



Аудитын гол асуудал

Монгол Улсын Засгийн газрын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар илэрсэн дараах зөрчлүүдийн дүн бидний тооцсон материаллаг байдлын түвшингээс давсан нь “Хязгаарлалттай” дүгнэлт өгөх үндэслэл болсон. Үүнд:

- Зээл, тусламжаар хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрийн хүрээнд бий болсон 338.6 тэрбум төгрөгийн хөрөнгийг санхүүгийн тайланд тусгаагүй;
- Дампуурсан банк, Хадгаламж зээлийн хоршооноос авах 437.6 тэрбум төгрөгийн найдваргүй, дамжуулан зээлийн 593.3 тэрбум, Засгийн газрын тусгай сангуудын 138.6 тэрбум төгрөгийн эргэн төлөгдөх хугацаа хэтэрсэн авлагын үлдэгдэлтэй;
- Гадаад зээлийн 23 төсөл, хөтөлбөрийн эх үүсвэрээс дамжуулан зээлдүүлсэн 649.5 тэрбум төгрөгийн зээлийг 35 байгууллага санхүүгийн тайланд өглөгөөр бүртгээгүй зэрэг зөрчлүүд нь санхүүгийн тайлагналын оршин байх, үнэн зөв, эрх ба үүрэг, толилуулга ба тодруулга батламж мэдэгдлүүдтэй нийцэхгүй байна.

Үүрэг хариуцлага

Сангийн яам Монгол Улсын Засгийн газрын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.1-д заасны дагуу нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланд дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.



Д.ЗАНДАНБАТ

АУДИТ ХИЙСЭН ЗАСГИЙН ГАЗРЫН 2019 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН

АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН БАЙДЛЫН ТАЙЛАН

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	14,687,883,432.4	21,006,560,185.1
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	4,625,684,273.4	6,148,944,340.3
32	БОГИНО ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	579,231,218.0	763,276,202.2
33	АВЛАГА	4,598,498,623.2	5,569,329,211.2
34	УРЬДЧИЛГАА	465,011,695.3	1,186,439,445.6
35	БАРАА МАТЕРИАЛ	1,564,015,806.8	2,039,502,256.6
36	НӨӨЦИЙН БАРАА	156,671,348.5	189,215,746.7
360	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	2,698,770,467.2	5,109,852,982.5
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	42,082,950,404.8	46,193,912,649.4
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	6,930,007,102.2	8,540,913,055.8
37100	Урт хугацаат хадгаламж	1,193,085,907.2	67,467,173.6
37200	Үнэт цаас	411,098,740.8	1,693,048,171.4
37300	Урт хугацаат зээл	5,325,822,454.2	6,780,397,710.8
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	35,152,943,302.6	37,652,999,593.6
39100	Газар	33,357,051.2	33,357,051.2
39200	Биет хөрөнгө	18,972,094,075.1	20,971,129,203.1
39300	Биет бус хөрөнгө	15,342,471,100.0	15,388,675,631.4
39400	Бусад хөрөнгө /ТӨҮГ/	805,021,076.4	1,259,837,707.9
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	56,770,833,837.2	67,200,472,834.5
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	29,798,446,538.8	33,178,696,000.8
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	3,016,665,830.0	3,521,882,442.4
41100	Богино хугацаат үнэт цаас	77,254,830.0	15,575,304.0
41200	Богино хугацаат зээлийн өглөг	1,362,191,567.2	1,441,547,672.1
41300	Өглөг	1,181,540,599.7	1,591,091,043.7
41400	Урьдчилж орсон орлого	395,678,833.1	473,668,422.6
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	26,781,780,708.8	29,656,813,558.5
42100	Урт хугацаат үнэт цаас	12,350,655,731.7	12,695,201,013.3
42200	Урт хугацаат зээл	14,431,124,977.1	16,961,612,545.2
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	26,972,387,298.4	34,021,776,833.7
51	Засгийн газрын хувь оролцоо	26,972,387,298.4	34,017,100,677.6
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	5,925,949,089.8	7,645,981,096.9
51101	Өмч /төрийн/ /ТӨҮГ/	3,602,487,360.2	3,351,062,633.5
51102	Өмч /хувийн/ /ТӨҮГ/	20,529,751.5	22,994,670.3
51103	Өмч /хувьцаат/ /ТӨҮГ/	11,266,724,265.2	11,285,344,372.1
51104	Халаасны хувьцаа /ТӨҮГ/	0.0	0.0
51105	Нэмж төлөгдсөн капитал /ТӨҮГ/	28,956,645.1	43,222,799.8
51106	Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/	4,482,252,837.6	5,214,618,821.9
51200	Хуримтлагдсан үр дүн	-5,092,235,447.4	-664,582,001.3
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	6,737,722,796.4	7,111,898,622.6
51400	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.0	-13,091,784.2
51500	Бодлогын өөрчлөлт алдааны залруулга	0.0	651,445.9
51600	Нөөцийн сан	0.0	19,000,000.0
52	Хяналтын бус хувь оролцоо	0.0	4,676,156.1
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	56,770,833,837.2	67,200,472,834.5

АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	15,883,926,099.5	20,563,906,478.0
11	ТАТВАРЫН ОРЛОГО	8,848,810,175.5	10,959,177,098.7
110	Орлогын албан татвар	2,421,504,963.4	2,968,371,433.0
1100	Хувь хүний орлогын албан татвар	855,953,325.8	933,148,175.5
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-41,895,217.5	-37,932,127.1
1102	Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч	307,011.6	263,878.9
1103	ААН-ын орлогын албан татвар	1,346,172,224.1	1,701,002,737.9
1104	Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татвар	260,967,619.4	371,888,767.8
112	Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого	1,699,082,364.2	2,225,796,363.6
113	Хөрөнгийн албан татвар	141,178,208.0	154,369,122.2
114	Нэмэгдсэн өртгийн албан татвар	2,195,907,230.8	2,486,268,106.2
115	Онцгой албан татвар	754,440,177.8	863,406,516.7
116	Тусгай зориулалтын орлого	13,063,741.0	16,355,040.0
117	Гадаад үйл ажиллагааны орлого	682,218,223.6	790,178,368.7
118	Бусад татвар, төлбөр, хураамж	941,415,266.7	1,454,432,148.3
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	6,592,792,736.8	9,163,883,989.7
120	Нийтлэг татварын бус орлого	6,374,519,476.4	8,977,157,071.4
121	Хөрөнгийн орлого	16,071,153.4	2,318,553.7
122	Тусламжийн орлого	197,993,163.8	181,145,607.2
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	756,056.6	44,117.6
124	Зээлийн орлого	3,452,886.6	3,218,639.8
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	442,323,187.2	440,845,389.6
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	12,182,730,488.8	13,926,514,817.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	11,542,348,286.9	13,843,742,907.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	6,773,187,193.0	9,029,492,467.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,148,967,594.9	2,562,706,853.5
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	218,019,608.0	272,343,520.1
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	269,861,021.2	291,144,426.0
2104	Хангамж, бараа материалын зардал	522,237,487.7	430,496,156.6
2105	Нормативт зардал	321,726,092.9	363,087,428.9
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	68,507,732.1	81,926,006.1
2107	Томилолт, зочны зардал	73,666,080.8	86,800,768.4
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,629,688,098.7	3,000,879,052.2
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,520,513,476.7	1,940,108,255.5
211	ХҮҮ	1,724,877,389.3	1,439,469,161.5
212	ТАТААС	242,712,135.4	278,652,752.8
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,801,571,569.2	3,096,128,525.6
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	640,382,201.9	82,771,909.8
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	3,701,195,610.7	6,637,391,660.9
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	303,358,950.4	2,592,436,359.1
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	3,288,409,036.9	5,007,961,545.3
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	716,145,524.2	4,221,866,474.8

АУДИТ ХИЙСЭН НЭГТГЭСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	17,453,749,426.0	0.0	17,453,749,426.0
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-347,559,723.5	0.0	-347,559,723.5
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	17,106,189,702.5	0.0	17,106,189,702.5
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	5,131,592,784.4	0.0	5,131,592,784.4
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	2,809,316,790.6	0.0	2,809,316,790.6
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-82,135,160.2	0.0	-82,135,160.2
7	Өмчид гарсан өөрчлөлт	1,298,848,141.6	0.0	1,298,848,141.6
8	Зарласан ногдол ашиг	-7,570,484.9	0.0	-7,570,484.9
9	Тайлант үеийн үр дүн	716,145,524.4	0.0	716,145,524.4
10	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	26,972,387,298.4	0.0	26,972,387,298.4
11	2019 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	26,972,387,298.4	0.0	26,972,387,298.4
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	654,267,982.3	0.0	654,267,982.3
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	27,626,655,280.7	0.0	27,626,655,280.7
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	169,475,985.4	0.0	169,475,985.4
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	1,190,791,908.6	0.0	1,190,791,908.6
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	15,151,010.8	0.0	15,151,010.8
17	Өмчид гарсан өөрчлөлт	1,046,941,337.5	0.0	1,046,941,337.5
18	Зарласан ногдол ашиг	-249,105,164.2	0.0	-249,105,164.2
19	Тайлант үеийн үр дүн	4,221,866,474.8	0.0	4,221,866,474.8
20	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	34,021,776,833.7	0.0	34,021,776,833.7

АУДИТ ХИЙСЭН НЭГТГЭСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	20,621,949,782.3	24,796,180,798.5
11	ТАТВАРЫН ОРЛОГО	8,868,311,637.0	10,955,778,262.3
110	Орлогын албан татвар	2,415,620,740.8	2,925,928,949.7
1100	Хувь хүний орлогын албан татвар	856,002,937.1	932,849,981.0
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-41,895,217.5	-37,932,127.1
1102	Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч	307,011.6	263,878.9
1103	ААН-ын орлогын албан татвар	1,346,018,243.8	1,699,775,630.0
1104	Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татвар	255,187,765.8	330,971,586.9
112	Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого	1,692,198,401.5	2,179,594,832.9
113	Хөрөнгийн албан татвар	141,176,636.1	154,369,122.2
114	Нэмэгдсэн өртгийн албан татвар	2,195,013,279.6	2,486,104,002.3
115	Онцгой албан татвар	754,090,177.8	863,401,414.0
116	Тусгай зориулалтын орлого	13,063,741.0	16,355,040.0
117	Гадаад үйл ажиллагааны орлого	684,321,383.3	790,179,283.2
118	Бусад татвар, төлбөр, хураамж	972,827,276.9	1,539,845,618.0
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	841,018,010.9	1,362,179,166.1
1181	Газрын төлбөр	66,662,717.4	110,100,350.0
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	57,492,615.1	58,975,575.3
1183	Бусад татвар	7,653,933.5	8,590,526.6
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	11,572,381,189.4	13,373,191,602.7
120	Нийтлэг татварын бус орлого	11,511,313,195.0	13,306,476,786.4
121	Хөрөнгийн орлого	11,182,845.6	1,733,479.8
122	Тусламжийн орлого	44,707,850.4	64,793,308.0
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	5,177,298.4	188,028.4
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	181,256,955.9	467,210,933.5
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	16,219,214,185.5	19,075,472,065.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ	16,219,214,185.5	19,075,472,065.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	11,675,805,855.3	13,778,098,638.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,566,024,458.2	3,356,462,191.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	339,854,395.1	495,295,078.4
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	333,680,946.2	591,257,245.4
2104	Хангамж, бараа материалын зардал	1,709,491,277.9	2,804,428,864.7
2105	Нормативт зардал	279,740,693.4	317,316,446.7
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	88,158,413.3	107,075,385.9
2107	Томилолт, зочны зардал	73,995,176.0	86,669,460.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,604,659,593.7	4,472,051,028.2
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	680,200,901.5	1,547,542,937.9
211	ХҮҮ	1,408,246,825.6	1,292,075,438.2
212	ТАТААС	236,308,579.8	293,298,104.2
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,898,852,924.8	3,711,999,884.3
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	4,402,735,596.8	5,720,708,733.1

IV	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)	69,288,298.6	369,559,826.2
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	2,070,488,802.9	4,669,892,436.4
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	2,070,488,802.9	4,669,892,436.4
2200	Дотоод эх үүсвэрээр	2,069,536,870.3	4,669,892,436.4
2260	Гадаад эх үүсвэрээр	951,932.6	0.0
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-2,001,200,504.3	-4,300,332,610.2
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-2,096,428,647.0	102,883,944.1
14	Бусад эх үүсвэр	2,175,548,304.0	2,171,342,295.1
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	1,006,490,403.6	403,621,615.0
24	ГАДААД ЗЭЭЛИЙН ҮНДСЭН ТӨЛБӨР	1,987,667,715.9	643,760,965.8
25	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	1,277,818,831.5	1,021,075,770.2
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	305,106,445.7	1,523,260,066.9
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	4,320,577,827.7	4,625,684,273.4
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	4,625,684,273.4	6,148,944,340.3



АУДИТЫН ТАЛААРХ ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ

Аудит хийсэн үндэслэл, хугацаа

Үндэсний аудитын газар Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.10.2-т заасны дагуу Засгийн газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайланд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Аудитын зорилт, хамарсан хүрээ

Засгийн газрын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, УСНББОУС, СТОУС-ын дагуу үнэн зөв илэрхийлэгдсэн эсэх талаар үндэслэлтэй баталгаагаар хууль тогтоох байгууллагыг хангахад энэхүү аудитын зорилт чиглэгдлээ.

Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан иж бүрэн бөгөөд үнэн зөв болохыг тодорхойлсон батламж мэдэгдэл, тайлбар, нэмэлт тодруулгуудыг Аудитын олон улсын стандартын дагуу сорьж шалгах нь аудитын горим юм.

Төрийн аудитын байгууллага Засгийн газрын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийж, дүгнэлт гаргахын өмнө Төрийн аудитын тухай болон Төсвийн тухай хуулийн дагуу төсвийн захирагчид, төсөл, хөтөлбөр, сан, төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой хуулийн этгээдийн 2019 оны санхүүгийн тайланд аудит хийж, дүгнэлт гаргасан болно.

Аудитын арга зүй

Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй баталгаа олж авахын тулд санхүүгийн нэгтгэсэн тайланг бэлтгэхэд баримталсан бодлого, зарчмыг үнэлж, санхүүгийн тайлангийн батламж мэдэгдлүүдийг үндсэн шалгуур болгон хяналтын сорил, шинжилгээний горим гүйцэтгэж, түүврээр ажил гүйлгээ, тооцооллыг давтан шалгаж, үнэлгээ өгөв.

Материаллаг байдлын түвшин

Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланд төсвийн байгууллага, төрийн сан, төсөл, хөтөлбөр, сан, төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой хуулийн этгээдийн санхүүгийн тайлангууд нэгтгэгддэг тул материаллаг байдлын түвшинг төлөвлөлтийн үе шатанд Засгийн газрын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардал 15,471.1 тэрбум төгрөгийн 2.0 хувь буюу 309.4 тэрбум төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг Засгийн газрын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардлаас тооцож 378.7 тэрбум төгрөгөөр тогтоолоо.

САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ХҮРЭЭ БА САНХҮҮГИЙН ТАЙЛАНГ НЭГТГЭХЭД БАРИМТАЛСАН АРГАЧЛАЛ, ЗАРЧИМ

Сангийн яам Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.1 дэх заалтын дагуу Засгийн газрын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг бэлтгэн, хуулийн хугацаанд Үндэсний аудитын газарт ирүүлсэн байна.

Санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу дараах байдлаар бэлтгэсэн байна. Үүнд:



Санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн байгууллага хооронд болон төсвийн ерөнхийлөн захирагч хооронд үүссэн 45,001.7 тэрбум төгрөгийн орлого болон зардлын давхардсан ажил гүйлгээ, өглөг, авлагыг цэвэрлэж тайлагнасан;

- Төсвийн байгууллага, төсөл сан, төрийн сан, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд гэсэн төрлөөр ангилан тайлагнасан байна.

Засгийн газрын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд 55 ТЕЗ-дын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тэдгээрийн харьяа 4470 төсвийн байгууллага, 370 төрийн сан, Засгийн газрын 22 тусгай сан, 549 төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой хуулийн этгээд, 134 төсөл хөтөлбөр, 997 орон нутаг дахь сангууд, хөрөнгө оруулалт болон зардлын санхүүгийн тайлан нийт 6542 санхүүгийн тайланг нэгтгэсэн байна.

Санхүүгийн тайланг бэлтгэсэн суурь

Засгийн газрын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг УСНББОУС, СТОУС-ын дагуу нягтлан бодох бүртгэлийн тохируулсан аккруэл сууриар бэлтгэсэн байна.

Тайланг илэрхийлсэн мөнгөний нэгж

Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь заалтын дагуу үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр, санхүүгийн нэгтгэсэн тайлан болон тодруулга тайланг мянган төгрөгөөр илэрхийлжээ.

Санхүүгийн тайлангийн бүтэц, бүрэлдэхүүн

Засгийн газрын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн яамны “Э-тайлан” программаар нэгтгэн гаргасан байна.

Засгийн газрын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дараах бүрэлдэхүүнтэй байна. Үүнд:

А. Үндсэн тайлан	Б. Байгууллагын төрлөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан	В. Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн тайлбар, тодруулга
Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан	Байгууллагын төрлөөрх санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан	НББ-ийн бодлого, зарчим 3-21 дүгээр тодруулгууд
Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан	Байгууллагын төрлөөрх санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан	1а, 1б, 2а, 2б тодруулга
Засгийн газрын нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	Байгууллагын төрлөөрх нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	
Засгийн газрын нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан	Байгууллагын төрлөөрх нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан	



Нягтлан бодох бүртгэлийн зарчим

Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө

Мөнгөн хөрөнгөнд касс, банкны харилцах дансанд байгаа мөнгө, хадгаламжийг бүртгэн тайлагнасан байна. Үүнд:

- Төрийн сангийн нэгдсэн дансны Монголбанк дахь үлдэгдэл;
- Төрийн сангийн орлогын ерөнхий дансдын үлдэгдэл;
- Төсвийн байгууллага, сангуудын төрийн сангийн харилцах данс дахь үлдэгдэл;
- Төсвийн байгууллага, төсөл, сангийн арилжааны банк дахь үлдэгдэл;
- Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн арилжааны банк дахь үлдэгдэл;
- Касст байгаа бэлэн мөнгө;
- Замд яваа мөнгөн хөрөнгө;
- Хадгаламж.

Богино хугацаат хөрөнгө оруулалт

Богино хугацаат хөрөнгө оруулалт дансанд 3 сараас нэг жилийн хугацаатай хадгаламж, авлага, өрийн болон өмчийн үнэт цаасны хөрөнгө оруулалтыг бүртгэж толилуулсан байна.

Авлага

Авлага дансанд үзүүлсэн ажил үйлчилгээ, нийлүүлсэн бүтээгдэхүүний төлбөр, зээлийн авлагыг бүртгэсэн байна.

Урьдчилгаа

Бэлтгэн нийлүүлэгчид бараа бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний урьдчилгаа болон урьдчилж төлсөн зардлуудыг бүртгэсэн байна.

Бараа материал

Бараа материалыг байнгын системийн аргаар бүртгэж, зарцуулах болон өртгийг тооцохдоо эхэлж авснаа эхэлж зарлагдах, дундаж өртгийн аргуудыг хэрэглэж байна.

Нөөцийн бараа

Байгалийн гамшиг, батлан хамгаалах болон дотоодын зах зээлийн улирлын шинж чанартай хэрэгцээг зохицуулах зорилгоор стратегийн ач холбогдолтой бүтээгдэхүүний нөөцийг бүртгэсэн байна.

Бусад эргэлтийн хөрөнгө

Хөрөнгө оруулалтаар хийгдэж байгаа төсөл, арга хэмжээ, шилжүүлээгүй хөрөнгийг хуримтлуулан бүртгэсэн байна.

Урт хугацаат хөрөнгө оруулалт

Засгийн газар, төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой хуулийн этгээд, олон улсын болон дотоодын банк, санхүүгийн байгууллагад оруулсан урт хугацаат хөрөнгө оруулалтуудыг хамруулсан байна.



Үндсэн хөрөнгө

Үйл ажиллагаандаа ашиглаж байгаа үндсэн хөрөнгийг өртгөөр, газар болон дуусаагүй барилгаас бусад үндсэн хөрөнгөд стандартаар хүлээн зөвшөөрсөн аргуудыг ашиглаж элэгдэл тооцсон байна.

Биет бус хөрөнгө

Биет шинж чанаргүй, ирээдүйд түүнээс өгөөж хүртэхийн тулд гаргасан зарлага, лиценз, эзэмших, ашиглах эрхийг бүртгэсэн байна.

Богино хугацаат өр төлбөр

Тухайн жилд төлөгдөх үнэт цаас, гадаад бонд, зээл, хүүгийн төлбөр, төсвийн байгууллага, төсөл сан, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн нэг жилийн дотор барагдуулах өр төлбөр, урьдчилж орсон орлогыг тайлагнасан байна.

Урт хугацаат өр төлбөр

Нэг жилээс дээш хугацаатай Засгийн газрын дотоод, гадаад үнэт цаас, зээл, төсөл сан, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн урт хугацаат бонд, зээл, дамжуулан зээлийн өглөг, хойшлогдсон өр төлбөрийг бүртгэсэн байна.

Болзошгүй өр төлбөр

Засгийн газрын өрийн баталгаа гаргасан төсөл, арга хэмжээ, концессын хүрээнд үүссэн болзошгүй өр төлбөрийн мэдээллийг Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн тодруулгад толилуулсан байна.

Орлого, зардлын хүлээн зөвшөөрөлт

Орлого, зардлыг тохируулсан аккурэл сууриар хүлээн зөвшөөрч тайлагнасан байна.

**АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН ТАЛААР****Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт**Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

Засгийн газрын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангаар нийт хөрөнгө болон өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн 67,200.5 тэрбум төгрөг болж, өмнөх оноос 18.4 хувиар нэмэгдсэн байна.

Хүснэгт №1. Нийт хөрөнгө ба нийт өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмч /сая төгрөг/

Тайлангийн үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Дүнд эзлэх хувь	
			Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
Эргэлтийн хөрөнгийн дүн	14,687,883.4	21,006,560.2	25.9	31.3
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	42,082,950.4	46,193,912.6	74.1	68.7
Нийт хөрөнгийн дүн	56,770,833.8	67,200,472.8	100.0	100.0
Нийт өр төлбөр	29,798,446.5	33,178,696.0	52.5	49.4
Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	26,972,387.3	34,021,776.8	47.5	50.6
Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	56,770,833.8	67,200,472.8	100.0	100.0

Эх сурвалж: Засгийн газрын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийт хөрөнгө өмнөх оноос 10,429.6 тэрбум төгрөгөөр өссөн нь төрийн болон орон нутгийн өмчийн 51-ээс дээш хувийн оролцоотой 13 хуулийн этгээдийн санхүүгийн тайланг нэгтгэсэн, орон нутгийн өмчит 14 хуулийн этгээд шинээр байгуулсантай холбоотой байна.

Нийт үлдэгдлийн дүнд эзлэх эргэлтийн бус хөрөнгө өмнөх оноос 5.4 пунктээр буурсан, цэвэр хөрөнгө/өмчийн дүн 3.1 пунктээр өссөн байна.

Санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

Засгийн газрын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангаар үйл ажиллагааны нийт үр дүн 4,221.8 тэрбум төгрөгөөр илэрхийлэгдсэн нь тайлант оны орлого зардлаасаа их байгаатай холбоотой болно.

Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд нийт 1,723.4 тэрбум төгрөгийн ашигтай, төсөвт байгууллагын үйл ажиллагааны үр дүн 1,715.4 тэрбум, төсөл сангийн үйл ажиллагааны үр дүн 1,821.9 тэрбум төгрөгийн тус тус эерэг /орлого нь зардлаасаа их/ үзүүлэлттэй, төрийн сангийн үйл ажиллагааны нийт үр дүн 1,039.2 тэрбум төгрөгийн сөрөг /зардал нь орлогоосоо их/ үзүүлэлттэй гарсан байна.

Нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Засгийн газрын 2019 оны нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлангаар засгийн газрын хувь оролцоо 7,044.7 тэрбум төгрөгөөр өссөн нь харьяа байгууллагуудын тайлант үеийн үр дүн нэмэгдсэн, төрийн болон орон нутгийн өмчийн 51-ээс дээш хувийн оролцоотой хуулийн этгээдийн санхүүгийн тайланг нэгтгэсэн, улс орон нутгийн хөрөнгө оруулалтаар засгийн газрын капитал данс нэмэгдсэн зэргээс шалтгаалсан байна.

Мөнгөн гүйлгээний нэгтгэсэн тайлан

Засгийн газрын 2019 оны мөнгөн гүйлгээний нэгтгэсэн тайлангаар мөнгөн орлого 27,337.1 тэрбум, зарлага 25,813.8 тэрбум, цэвэр мөнгөн гүйлгээ 1,523.3 тэрбум төгрөгөөр илэрхийлэгдсэн байна.

АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА, АУДИТЫН ДҮН

Нэг. МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 4,625.7 тэрбум, эцсийн үлдэгдэл 6,148.9 тэрбум төгрөг болж, 1,523.2 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №2. Мөнгөн хөрөнгө дансын ангилал, байгууллагын төрлөөр /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Касст байгаа бэлэн мөнгө	46,887.3	59,787.4	12,900.1	1.0
Банканд байгаа бэлэн мөнгө	3,366,148.4	4,815,508.5	1,449,360.1	78.3
Замд яваа мөнгөн хөрөнгө	12,670.1	67,400.0	54,729.9	1.1
Хадгаламж	1,199,978.5	1,206,248.4	6,269.9	19.6
Дүн	4,625,684.3	6,148,944.3	1,523,260.0	100.0
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>				
Төсөвт байгууллага	278,538.9	323,762.1	45,223.2	5.3
Төсөл/ сан	1,479,190.0	2,097,164.7	617,974.7	34.1
Төрийн сан	262,655.5	1,098,823.1	836,167.6	17.9
ТӨҮГ болон ОНӨҮГ	2,605,299.9	2,629,194.4	23,894.5	42.7
Дүн	4,625,684.3	6,148,944.3	1,523,260.0	100.0

Эх сурвалж: Засгийн газрын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгө өмнөх оноос өссөн нь төсвийн орлого төлөвлөснөөс 767.8 тэрбум төгрөгөөр давсан, НДШ-ийн хувь хэмжээ 1 пунктээр нэмэгдсэнтэй холбоотой байна. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл нь дараа жилийн улирлын чанартай төсвийн дутагдлын эх үүсвэрт ашиглагдах ач холбогдолтой байна.

Банканд байршиж буй 4,815.5 тэрбум төгрөгөөс гадаад валютаарх үлдэгдэл 1,725.9 тэрбум төгрөг байна. Үүнээс 867.4 тэрбум төгрөг нь төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, 724.4 тэрбум төгрөг нь төрийн сан, 96.5 тэрбум төгрөг нь төсөл, сан, 37.6 тэрбум төгрөг нь төсөвт байгууллагын үлдэгдэл байна.

Арилжааны банканд байршиж буй нийт 4,051.4 тэрбум төгрөгийн 52.0 хувь нь төрийн болон орон нутгийн өмчийн хуулийн этгээдийн, 29.6 хувь нь Нийгмийн даатгалын сан, 12.9 хувь нь Эрүүл мэндийн даатгалын сан, 5.5 хувь нь төсөвт байгууллага, бусад төсөл, сангийн үлдэгдэл байна.

Хүснэгт №3. Төрийн байгууллагын хадгаламж дахь мөнгөн хөрөнгө /сая төгрөг/

Байгууллага	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Нийгмийн даатгалын сан	439,335.0	484,280.0	44,945.0	40.1
Эрүүл мэндийн даатгалын сан	416,000.0	233,000.0	-183,000.0	19.3
Эрдэнэс Тавантолгой ХК	-	150,000.0	150,000.0	12.4
Монгол Улсын Хөгжлийн банк ХХК	309,972.9	145,495.0	-164,477.9	12.1
Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ	-	115,081.4	115,081.4	9.5
Төрийн банк ХХК	-	55,013.6	55,013.6	4.6
Бусад	34,670.6	23,378.5	-11,292.1	1.9
Дүн	1,199,978.5	1,206,248.5	6,269.9	100.0

Эх сурвалж: Засгийн газрын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Хадгаламж дахь мөнгөн хөрөнгийн өөрчлөлтөд Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын санхүүгийн тайланг нэгтгэснээс 115.1 тэрбум, Эрдэнэс Тавантолгой ХК 150.0 тэрбум, Төрийн банк 55.0 тэрбум төгрөгийн хадгаламжийг тус тус шинээр байршуулснаар нэмэгдэж, ЭМДС татан буугдсан Капитал банкны хадгаламж 128.0 тэрбум төгрөгийг авлагын дансанд шилжүүлэн бүртгэсэн, Хөгжлийн банк 164.5 тэрбум төгрөгийн хадгаламжийг харилцах дансанд татсан зэрэг голлон нөлөөлсөн байна.

Өв төрийн сангийн мөнгөн хөрөнгө

Төв төрийн сангийн мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 187.3 тэрбум, эцсийн үлдэгдэл 798.6 тэрбум болж, 611.3 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №4. Төв төрийн сангийн мөнгөн хөрөнгө /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт(+), Бууралт(-)
Банканд байгаа мөнгөн хөрөнгө	180,775.1	746,011.6	565,236.5
Төгрөг	34,206.7	38,765.6	4,558.9
Төрийн сан	17,814.1	29,343.8	11,529.7
Монголбанк	8,340.0	8,688.2	348.2
Арилжааны банк	8,052.6	733.6	-7,319.0
Гадаад валют	146,568.4	707,246.0	560,677.6
Монголбанк	146,568.4	707,246.0	560,677.6
Замд яваа мөнгөн хөрөнгө	6,545.3	52,616.4	46,071.1
Нийт дүн	187,320.4	798,628.0	611,307.6

Эх сурвалж: Засгийн газрын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдлийн 4.9 хувийг төгрөгийн, 88.6 хувийг гадаад валютын харилцах, 6.5 хувийг замд яваа мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл эзэлж байна.

Төв төрийн сангийн Монголбанк дахь валютын харилцахын үлдэгдэлд оны эцэст донор байгууллагаас шилжүүлсэн Төсөв, санхүүгийн тогтвортой байдлыг дэмжих төсөл-2, Улаанбаатар хотын агаарын чанарыг сайжруулах хөтөлбөрийн нийт 408.1 тэрбум төгрөгийн санхүүжилт байна.

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 187.3 тэрбум, тайлант онд үйл ажиллагааны орлогоос 8,584.2 тэрбум, зээлийн эргэн төлөлтөөс 569.1 тэрбум, зээлийн эх үүсвэрээс 765.5 тэрбум, нийт 9,918.8 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлж, урсгал зардалд 6,273.5 тэрбум, хөрөнгө оруулалтын зардалд 1,560.4 тэрбум, зээлийн эргэн төлөлт, ханшийн зөрүү 1,473.6 тэрбум, нийт 9,307.5 тэрбум төгрөгийг зарцуулж, оны эцэст 798.6 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Төв төрийн сан улсын төсвийн зарлагын эх үүсвэрийн дутагдал 743.0 тэрбум төгрөгийг төрийн сангийн нэгдсэн данснаас бүрдүүлж санхүүжүүлсэн байна.

Аудитын илрүүлэлт:

- Төв төрийн сангийн мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл, дансны үлдэгдлийн баталгааны дүнгээс 105.6 тэрбум төгрөгөөр зөрүүтэй.

Нийгмийн даатгалын сангийн мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 948.5 тэрбум, эцсийн үлдэгдэл 1,262.6 тэрбум болж, 314.1 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №5. Нийгмийн даатгалын сангийн мөнгөн хөрөнгө /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+) Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Банканд байгаа бэлэн мөнгө	509,196.4	778,306.2	269,109.8	61.7
Төрийн сангийн харилцах	84,051.9	62,768.8	-21,283.1	5.0
Нэмэлт санхүүжилт	2.2	22.3	20.1	0.0
Арилжааны банкны харилцах	425,142.3	715,515.1	290,372.8	56.7
Хадгаламж	439,335.0	484,280.0	44,945.0	38.3
Нийт дүн	948,531.4	1,262,586.2	314,054.8	100.0
Үүнээс, сангийн төрлөөр				
Тэтгэврийн даатгал	149,128.9	381,121.2	231,992.3	30.2
Тэтгэмжийн даатгал	32,795.9	61,025.1	28,229.2	4.8
ҮОМШӨ-ний даатгал	608,576.8	707,808.6	99,231.8	56.1
Ажилгүйдлийн даатгал	142,019.9	101,471.1	-40,548.8	8.0
Эрүүл мэндийн даатгал	11,267.0	7,776.3	-3,490.7	0.6
Бусад	4,742.9	3,383.9	-1,359.0	0.3
Дүн	948,531.4	1,262,586.2	314,054.8	100.0

Эх сурвалж: Нийгмийн даатгалын сангийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан



рилжааны банк дахь харилцах, хадгаламж өмнөх оноос 335.3 тэрбум төгрөгөөр өссөн нь даатгалын шимтгэлийн хувь хэмжээ өмнөх оноос 1 пунктээр нэмэгдсэн, банкны хүүгийн орлого өссөнтэй холбоотой байна.

Хүснэгт №6. Арилжааны банкуудад байршуулсан хадгаламж /сая төгрөг/

№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт(+), Бууралт(-)	Дүнд эзлэх хувь
1	Улаанбаатар хотын банк	68,355.0	33,900.0	-34,455.0	7.0
2	Голомт банк	100,580.0	2,550.0	-98,030.0	0.5
3	Капитал банк	2,400.0	-	-2,400.0	-
4	Капитрон банк	16,900.0	12,020.0	-4,880.0	2.5
5	Төрийн банк	50,000.0	128,000.0	78,000.0	26.4
6	Үндэсний хөрөнгө оруулалтын банк	31,830.0	5,030.0	-26,800.0	1.0
7	Хаан банк	54,000.0	170,000.0	116,000.0	35.1
8	Чингис хаан банк	70,120.0	57,180.0	-12,940.0	11.8
9	Кредит банк	-	29,000.0	29,000.0	6.0
10	Тээвэр хөгжлийн банк	45,000.0	45,000.0	-	9.3
11	Худалдаа хөгжлийн банк	150.0	1,600.0	1,450.0	0.4
Дүн		439,335.0	484,280.0	44,945.0	100.0

Эх сурвалж: Нийгмийн даатгалын сангийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Сангийн мөнгөн хөрөнгийн чөлөөт үлдэгдлээс байршуулсан хадгаламж 484.3 тэрбум төгрөгийн 95.5 хувь буюу 462.8 тэрбум төгрөг үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний, 2.2 хувь буюу 10.5 тэрбум төгрөг тэтгэмжийн, 2.3 хувь буюу 11.0 тэрбум төгрөг ажилгүйдлийн даатгалын сангийн хадгаламж эзэлж байна.

Хүснэгт №7. Хадгаламжийн хүүгийн өөрчлөлт

Монголбанкны бодлогын хүү		НДҮЗ-ийн тогтоол	
Огноо	Хүүгийн хэмжээ	Огноо, дугаар	Хүүгийн хэмжээ
2016.12.19	14%	2016.12.15 №33	15%
2017.03.17	14%		
2017.06.15	12%		
2017.12.25	11%		
2018.03.23	10%	2018.08.17 №09	13%
2018.11.28	11%	2018.12.24 №13	14%
2020.03.12	10%		
2020.04.14	9%		

Хадгаламжийн хүүг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2016 оны 33 дугаар тогтоолоор 15.0 хувь болгосон ба 2018 оны 3 дугаар сард 13.0 хувь, 11 дүгээр сард 14.0 хувь болж хүүгийн хэмжээ өөрчлөгдсөн байна.

Эх сурвалж: Нийгмийн даатгалын ерөнхий газар

Эрүүл мэндийн даатгалын сангийн мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 527.5 тэрбум, эцсийн үлдэгдэл 557.5 тэрбум болж, 30.0 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №8. Эрүүл мэндийн даатгалын сангийн мөнгөн хөрөнгө /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт(+), Бууралт(-)	Дүнд эзлэх хувь
Харилцах данс	111,514.5	324,520.3	213,005.8	58.2
Төрийн сангийн харилцах	639.5	35,693.5	35,054.0	6.4
Арилжааны банкны харилцах	110,875.1	288,826.8	177,951.7	51.8
Хадгаламж	416,000.0	233,000.0	-183,000.0	41.8
Дүн	527,514.5	557,520.3	30,005.8	100.0

Эх сурвалж: Эрүүл мэндийн даатгалын сангийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Хадгаламж 183.0 тэрбум төгрөгөөр буурч, харилцах дансны мөнгөн хөрөнгө 213.0 тэрбум төгрөгөөр өссөн нь татан буугдсан Капитал банканд байршиж байсан 128.0 тэрбум төгрөгийн хадгаламжийг эрх хүлээн авагчаас авах авлагаар бүртгэсэн, 55.0 тэрбум төгрөгийн хадгаламжийг

арилцах дансанд шилжүүлсэн, үйл ажиллагааны орлогын зарцуулагдаагүй үлдэгдэл 158.0 тэрбум төгрөгөөр нэмэгдсэнтэй холбоотой байна.

Хүснэгт №9. Арилжааны банкуудад байршуулсан хадгаламж /сая төгрөг/

№	Банкны нэр	Дундаж хүү	Эцсийн үлдэгдэл	Дүнд эзлэх хувь	Тайлант онд сангийн мөнгөн хөрөнгийн чөлөөт үлдэгдлээс 233.0 тэрбум төгрөгийн хадгаламжийг арилжааны банканд байршуулж, хүүгийн орлого 33.1 тэрбум төгрөгийг төвлөрүүлсэн байна.
1	Худалдаа хөгжлийн банк	12.0%	10,000.0	4.3	
2	Улаанбаатар хотын банк	12.0%	20,000.0	8.6	
3	Капитрон банк	12.0%	20,000.0	8.6	
4	Хас банк	12.4%	20,000.0	8.6	
5	Хаан банк	12.5%	65,000.0	27.9	
6	Голомт банк	11.5%	38,000.0	16.3	
7	Төрийн банк	13.2%	60,000.0	25.7	
Дүн			233,000.0	100.0	

Эх сурвалж: Эрүүл мэндийн даатгалын сангийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Аудитын илрүүлэлт:

- Нэр бүхий 2 арилжааны банкны хэвийн үйл ажиллагаа алдагдаж, төлбөр гүйцэтгэх чадвар буурснаас 8.0 тэрбум төгрөгийн төлбөр тооцоог гүйцэтгээгүй;
- Хөрөнгийн зохист харьцаа тогтоох тухай ЭМДҮЗ-ийн 2018 оны 14 дүгээр тогтоолоор баталсан харилцах дансанд байвал зохих хөрөнгийн хэмжээнээс давсан мөнгөн хөрөнгийг хадгаламжид байршуулаагүйгээс 7.6 тэрбум төгрөгийн хүүгийн орлого олох боломжийг алдсан.

Төсвийн ерөнхийлөн захирагчдын мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 3,546.4 тэрбум, эцсийн үлдэгдэл 4,085.6 тэрбум болж, 539.2 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №10. Улс, орон нутгийн ТЕЗ-дын мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Төсөвт байгууллага	Төрийн сан	Төсөл/ Сангууд	ТӨҮГ болон ОНӨҮГ	Дүн
Касст байгаа бэлэн мөнгө	945.6	0.1	1.6	58,837.5	59,784.9
Банканд байгаа бэлэн мөнгө	319,773.0	288,453.5	597,452.7	2,083,439.2	3,289,118.3
Замд яваа мөнгөн хөрөнгө	2,553.3	11,741.4	-	449.0	14,743.7
Хадгаламж	-	-	235,500.0	486,468.4	721,968.4
Дүн	323,271.9	300,195.0	832,954.3	2,629,194.0	4,085,615.2
Үүнээс,					
УТЕЗ	89,960.7	300,187.0	45,095.3	179,808.2	615,051.3
ОНТЕЗ	233,311.1	8.0	787,859.0	2,449,385.9	3,470,564.0
Дүн	323,271.9	300,195.0	832,954.3	2,629,194.0	4,085,615.2

Эх сурвалж: Засгийн газрын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын 2019 оны 12 дугаар сарын Улсын төсвийн хөрөнгө оруулалтын талаар авах зарим арга хэмжээний тухай 430 дугаар тогтоолоор тайланд онд хэрэгжээгүй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжилт 159.7 тэрбум төгрөгийг 10 ТЕЗ-дын барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан байна.

Хүснэгт №11. Барьцаа дансанд шилжүүлсэн хөрөнгө оруулалтын санхүүжилт /сая төгрөг/

№	Төсвийн ерөнхийлөн захирагчид	Хөрөнгө оруулалтын төсөв	Барьцаа дансанд шилжүүлсэн
1	Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга	38,714.0	2,879.8
2	Сангийн сайд	134,386.3	35,013.0
3	Эрүүл мэндийн сайд	104,238.0	17,249.6
4	Байгаль орчин, аялал жуулчлалын сайд	13,776.2	2,189.3
5	Барилга, хот байгуулалтын сайд	141,350.1	3,421.7
6	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд	616,453.7	58,951.0
7	Зам, тээврийн хөгжлийн сайд	241,781.9	26,991.0
8	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд	29,533.0	3,899.6
9	Эрчим хүчний сайд	97,150.3	3,497.1
10	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд	33,895.4	5,581.9
Дүн		1,451,278.9	159,674.0

Эх сурвалж: Сангийн яамны Төсвийн хөрөнгө оруулалтын газраас ирүүлсэн судалгаа

Аудитын илрүүлэлт:

- Мөнгөн хөрөнгийн эрсдэлийн удирдлагын тогтолцоог бүрдүүлэх, арилжааны банканд мөнгөн хөрөнгө байршуулахад баримтлах нэгдсэн бодлого, чиглэл, эрх зүйн зохицуулалтгүй;
- Эрсдэл үүсэж болзошгүй зарим арилжааны банкнуудад төрийн байгууллагуудын 317.8 тэрбум төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй;
- Монгол Улсын Хөгжлийн банкны мөнгөн хөрөнгөд татан буугдсан Капитал банканд байршиж байсан 1.8 тэрбум төгрөг бүртгэлтэй;
- Сангийн яамны зөвшөөрөлгүйгээр арилжааны банканд 5 харилцах данс нээсэн;
- Төрийн өмчит хуулийн этгээдийн ногдол ашгаас төсөвт төвлөрүүлэх орлогыг МИАТ ТӨХК 7.3 тэрбум, Сэргээгдэх эрчим хүчний төв ТӨҮГ 0.06 тэрбум төгрөг дутуу төвлөрүүлсэн;
- Үндэсний хөгжлийн газар хөрөнгө оруулалтын техник хяналтын зардлаас хэмнэгдсэн 3.0 тэрбум, концессын төлбөр 1.5 тэрбум, Нийгмийн халамжийн сангийн зарцуулаагүй үлдэгдэл 1.1 тэрбум төгрөгийг төсөвт төвлөрүүлээгүй;
- Орон нутгийн өмчит Таван толгой ХК нь эрх бүхий байгууллагын шийдвэргүйгээр хадгаламж зээлийн хоршоонд 2.0 тэрбум төгрөгийн мөнгөн хадгаламж байршуулсан;
- Цахим и-баримтын дүнгээс бараа материал, ажил үйлчилгээний төлбөрийг зөрүүтэй шилжүүлсэн, и-баримтгүй худалдан авалт хийсэн 3.4 тэрбум төгрөгийн зөрчил; /Нийслэл 3.0 тэрбум, Говь-Алтай 0.4 тэрбум төгрөг/;
- Мөнгөн кассын үйл ажиллагааны журмыг зөрчсөн, мөнгөн гүйлгээний тайланг зөрүүтэй илэрхийлсэн, анхан шатны баримтгүй, бүрдэл дутуу, хүчин төгөлдөр бус баримтаар ажил гүйлгээг хүлээн зөвшөөрсөн зэрэг нийт 4.6 тэрбум төгрөгийн зөрчил; /Үүнд: ХЗДХЯ 0.1 тэрбум, ҮСХ 0.04 тэрбум, БОАЖЯ 0.03 тэрбум, ЕТГ 0.02 тэрбум, ЗТХЯ 0.01 тэрбум, Нийслэл 2.5 тэрбум, Дархан-Уул 1.1 тэрбум, Орхон 0.3 тэрбум, Дорнод 0.2 тэрбум, Сүхбаатар 0.1 тэрбум, Сэлэнгэ 0.1 тэрбум, Өвөрхангай 0.1 тэрбум, Увс 0.01 тэрбум, Хэнтий 0.01 тэрбум төгрөг/

Хоёр. БОГИНО ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

Богино хугацаат хөрөнгө оруулалт дансны эхний үлдэгдэл 579.2 тэрбум, эцсийн үлдэгдэл 763.2 тэрбум болж, 184.0 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №12. Богино хугацаат хөрөнгө оруулалт, байгууллагаар /сая төгрөг/

Байгууллага	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Боловсролын зээлийн сан	1,416.1	1,023.7	-392.4	0.1
МИАТ ТӨХК	42,170.6	34,147.4	-8,023.2	4.5
Монголын Цахилгаан холбоо ХК	5,831.5	-	-5,831.5	
Монгол Улсын Хөгжлийн банк ХХК	28,394.8	-	-28,394.8	
Монголын хөрөнгийн бирж ХХК	1.0	1.0	-	0
Төрийн банк ХХК	501,417.2	728,104.1	226,686.9	95.4
Дүн	579,231.2	763,276.2	184,045.0	100.0

Эх сурвалж: Засгийн газрын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Богино хугацаат хөрөнгө оруулалт өссөн нь Төрийн банк дахь Монголбанкны үнэт цаас 226.7 тэрбум төгрөгөөр нэмэгдсэнээс шалтгаалжээ.

Засгийн газрын 2016 оны 111, 2017 оны 176 дугаар тогтоолын дагуу Боловсролын зээлийн сангаас Оюутны хөгжлийн зээлийн хөтөлбөрийн үлдэгдэл 1.0 тэрбум, арилжааны 7 банканд 3 сараас 1 жилийн хугацаатай байршуулсан МИАТ ТӨХК-ийн хадгаламж 34.1 тэрбум төгрөг байна.

Гурав. АВЛАГА

Авлага дансны эхний үлдэгдэл 4,598.5 тэрбум, эцсийн үлдэгдэл 5,569.3 тэрбум болж, 970.8 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №13. Авлага дансны ангилал, байгууллагын төрлөөр /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Ажиллагчидтай холбогдсон авлага	2,050.1	2,565.4	515.3	0.1
Төлбөртэй үйлчилгээний авлага	331,882.8	362,428.1	30,545.3	6.5
Татаас, санхүүжилтийн авлага	13,136.0	28,282.2	15,146.2	0.5



Зээлийн хүүгийн авлага	181,938.9	148,846.9	-33,092.0	2.7
Дансны авлага /ТӨҮГ/	634,679.8	1,346,876.5	712,196.7	24.2
Татвар, НДШ-ийн авлага /ТӨҮГ/	55,883.3	53,804.6	-2,078.7	1.0
Бусад авлага	1,100,558.9	1,113,299.4	12,740.5	20.0
Зээлийн авлага	2,278,368.8	2,513,226.2	234,857.4	45.0
Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн авлага	1,248,521.4	1,155,825.8	-92,695.6	
Гадаад зээлээс дамжуулан зээлдүүлсэн авлага	1,029,847.4	1,357,400.4	327,553.0	
Дүн	4,598,498.6	5,569,329.2	970,830.6	100.0
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>				
ТӨҮГ болон ОНӨҮГ	1,691,415.0	2,062,895.9	371,480.9	37.1
Төрийн сан	1,436,093.7	1,726,747.7	290,654.0	31.0
Төсөвт байгууллага	1,192,653.0	1,221,477.9	28,824.9	21.9
Төсөл/Сан	278,336.9	558,207.7	279,870.8	10.0
Дүн	4,598,498.6	5,569,329.2	970,830.6	100.0

Эх сурвалж: Засгийн газрын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлагын өсөлтийн 73.4 хувь нь дансны авлага, 24.2 хувь нь зээлийн авлага байна. Дансны авлага болон зээлийн авлагын өсөлтөд төрийн өмчит хуулийн этгээдүүдийн авлага, дамжуулан зээлийн ашиглалт, татан буугдсан Капитал банк дахь мөнгөн хөрөнгийг авлага дансанд шилжүүлсэн нь голлон нөлөөлсөн байна.

Авлага дансны нийт үлдэгдлийн 7.8 хувь буюу 437.6 тэрбум төгрөг нь дампуурсан банк, Хадгаламж, зээлийн хоршооноос авах найдваргүй авлага байна.

Хүснэгт №14. Дампуурсан банкнаас авах авлага төсөв захирагчдаар: /сая төгрөг/

Байгууллага	УТЕЗ	ОНТЕЗ	Нийт	Найдваргүй авлагыг төсвийн ерөнхийлөн захирагчдаар харуулбал: ЭМДС 136.1 тэрбум, Төрийн сан 131.9 тэрбум, НДС 109.4 тэрбум, ХХААХҮЯ 42.9 тэрбум, БСШУСЯ 6.0 тэрбум, ХНХЯ 2.4 тэрбум, ОНТЕЗ 6.5 тэрбум, бусад 2.4 тэрбум төгрөг байна.
Азийн хөрөнгө оруулалтын банк	19.6	-	19.6	
Анод банк	24,017.1	0.3	24,017.4	
ХОТШ банк	1,846.9	127.2	1,974.1	
Сэргээн босголт банк	2,088.1	19.9	2,108.0	
Эксим банк	753.2	-	753.2	
Ард, даатгал банк	985.1	22.7	1,007.8	
Зоос банк	58,484.7	-	58,484.7	
Хадгаламж банк	2.7	-	2.7	
Капитал банк	293,042.5	6,304.7	299,347.2	
Хадгаламж зээлийн хоршоо	49,868.8	-	49,868.8	
Дүн	431,108.7	6,474.8	437,583.5	

Эх сурвалж: Төсөв захирагчдаас ирүүлсэн судалгааны нэгтгэл

Банк, санхүүгийн байгууллагуудын засаглал, менежментийн үйл ажиллагааны доголдлоос шалтгаалан найдваргүй авлага үүсэж, төрийн хөрөнгөд хохирол учирч байна.

Төв төрийн сангийн авлага

Төв төрийн сангийн авлагын эхний үлдэгдэл 1,430.4 тэрбум, эцсийн үлдэгдэл 1,721.2 тэрбум болж, 290.8 тэрбум төгрөгөөр өссөн, нийт авлагын 78.1 хувь буюу 1,344.5 тэрбум төгрөг нь дамжуулан зээлийн авлага байна.

Хүснэгт №15. Төв төрийн сангийн авлага /сая төгрөг/

Харилцагч байгууллага	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Зээлийн хүүгийн авлага	2,724.5	1,159.4	-1,565.1
Бусад авлага	374,824.1	317,238.2	-57,585.9
Зээлийн авлага	1,052,885.2	1,402,871.8	349,986.6
Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн авлага	27,888.0	58,353.3	30,465.3
Гадаад зээлээс дамжуулан зээлдүүлсэн авлага	1,024,997.2	1,344,518.5	319,521.3
Дүн	1,430,433.8	1,721,269.4	290,835.6

Эх сурвалж: Төв төрийн сангийн 2019 оны санхүүгийн тайлан

адаад зээлээс 14 төсөл, хөтөлбөрт зориулан дамжуулан зээлдүүлсэн 250.9 тэрбум төгрөгийн зээлийн ашиглалтаар авлага нэмэгдэж, арилжааны банкуудаар дамжуулан олгосон орон сууцны 58.5 тэрбум төгрөгийн зээлийн эргэн төлөлтөөр буурчээ.

Гадаад зээлээс дамжуулан зээлдүүлсэн зээлийн авлага

Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг дамжуулан зээлдүүлсэн зээлийн авлагын эхний үлдэгдэл 1,029.8 тэрбум, эцсийн үлдэгдэл 1,357.4 тэрбум төгрөг болж, 327.6 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №16. Дамжуулан зээлдүүлсэн зээлийн авлага /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
ЗГ-ын байгууллага, бусад шатны төсөвт олгосон	155,326.2	573,580.7	418,254.5
Төрийн өмчит аж ахуйн нэгжүүдэд олгосон	452,197.6	530,788.1	78,590.5
Хувийн хэвшлийн аж ахуйн нэгжид олгосон	422,323.5	253,031.6	-169,291.9
Дүн	1,029,847.3	1,357,400.4	327,553.1
<i>Үүнээс:</i>			
Гадаад зээлээс дамжуулсан зээл	1,024,997.2	1,344,518.5	319,521.3
Бусад дамжуулан зээл	4,850.1	12,881.9	8,031.8
Дүн	1,029,847.3	1,357,400.4	327,553.1

Эх сурвалж: Засгийн газрын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Дамжуулан зээлийн авлага өссөн нь дараах шалтгаантай байна. Тухайлбал: аудитын зөвлөмжөөр нэмж бүртгэсэн 102.4 тэрбум, тайлант оны ашиглалт УТЕЗ-дын харьяа байгууллагууд 192.7 тэрбум, ОНТЕЗ 88.1 тэрбум, валютын ханшийн зөрүүнээс 140.7 тэрбум төгрөг.

Дамжуулан зээлийн үндсэн төлбөрт 34.3 тэрбум, хүүгийн төлбөрт 16.1 тэрбум нийт 50.4 тэрбум төгрөгийг тайлант онд улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Аудитын илрүүлэлт:

- 1991-1996 онуудад 92 хувийн хэвшлийн байгууллагад олгосон 302.6 тэрбум төгрөгийн олон жилийн насжилттай, дамжуулан зээлийн найдваргүй авлага бүртгэлтэй;
- Эргэн төлөлт хийгдэхгүй байгаа ОНТЕЗ-дын байгууллагуудад 260.1 тэрбум, УТЕЗ-дын байгууллагуудад 608.2 тэрбум төгрөгийн дамжуулан зээлийн авлагаас жилийн эцсийн байдлаар 290.7 тэрбум төгрөгийн хугацаа хэтэрсэн авлагын үлдэгдэлтэй;
- 1996-2005 онд дамжуулан зээлсэн 6.1 тэрбум төгрөгийн авлагыг хөрөнгө оруулалтаар бүртгэх шийдвэрийг хэрэгжүүлээгүй;
- Засгийн газрын 2015 оны 464 дүгээр тогтоолыг үндэслэн Эрдэнэтийн дулааны цахилгаан станцын шинэчлэл төслийн 72.3 тэрбум төгрөгийн дамжуулан зээлийн авлагыг бүртгээгүй;
- Даланзадгад ДЦС ТӨХК-иас авах 2.2 тэрбум төгрөгийн шүүхийн шийдвэрээр хэрэгсэхгүй болгосон авлагыг данс бүртгэлээс хасаагүй;
- Засгийн газрын 2005 оны 252 дугаар тогтоолыг үндэслэн Тээвэр сэргээх төслийн хүрээнд 1995-1997 онуудад төслийн валютын ханшийн зөрүүгээс үүссэн 24.1 тэрбум төгрөгийг санхүүгийн тайланд авлагаар бүртгэсэн;
- Хэрэгжиж дууссан Тогтвортой амьжиргаа-2 төслийг хаагаагүй, төслөөс үлдсэн хөрөнгийг ашиглаж байгаа Бичил санхүүгийн хөгжлийн сангийн дамжуулан зээлийн өглөг, Төв төрийн сангийн авлага 5.1 тэрбум төгрөгөөр зөрүүтэй.

Дамжуулан зээлийн эргэн төлөлт хийгдэхгүй байгаа 1,170.9 тэрбум төгрөгийн авлагатай байгаа нь гадаад зээлийн өр төлөхөд дарамт учирч, эргэлтийн хөрөнгийн түргэн хөрвөх чадварт сөрөг үр дагавартай байна.

Төсөвт байгууллагын авлага

Төсөвт байгууллагуудын авлагын дансны эхний үлдэгдэл 1,192.7 тэрбум, эцсийн үлдэгдэл 1,221.5 тэрбум болж, 28.8 тэрбум төгрөгөөр өссөн байна.



Хүснэгт №17. Төсөвт байгууллагын авлага /сая төгрөг/

Төсөвт байгууллага	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Улсын төсвийн ерөнхийлөн захирагчид	1,051,272.5	1,079,734.1	28,461.6
Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчид	141,380.5	141,743.8	363.3
Дүн	1,192,653.0	1,221,477.9	28,824.9

Эх сурвалж: Засгийн газрын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Төсөвт байгууллагын авлагын үлдэгдэлд ХХААХҮЯ 436.6 тэрбум, БСШУСЯ 220.9 тэрбум, Сангийн яам 214.6 тэрбум, ХНХЯ 91.5 тэрбум, ХЗДХЯ 77.6 тэрбум, ОНТЕЗ 141.7 тэрбум, бусад УТЕЗ 38.6 тэрбум төгрөгийг эзэлж байна.

Улсын болон орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдын авлагатай холбоотой нийт 109.0 тэрбум төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн байна.

Аудитын илрүүлэлт:

- Олон жилийн насжилттай 60.9 тэрбум төгрөгийн авлагыг барагдуулж ажиллаагүй /ХНХЯ 27.5 тэрбум, ХХААХҮЯ 0.3 тэрбум, ОНТЕЗ 15.7 тэрбум, ЗТХЯ 13.4 тэрбум, НДС 4.0 тэрбум төгрөг/;
- Тооцоо нийлж баталгаажуулаагүй 43.2 тэрбум төгрөгийн авлага /ЭМДС 26.5 тэрбум, ГХЯ 2.3 тэрбум, НДС 1.1 тэрбум, ЗТХЯ 1.1 тэрбум, УУХҮЯ 0.5 тэрбум, ЭХЯ 0.3 тэрбум, МУЕС 0.3 тэрбум, ОНТЕЗ 11.1 тэрбум төгрөг/;
- Авлагыг нягтлан бодох бүртгэлд зөрүүтэй тайлагнасан /НДС 2.0 тэрбум, ОНТЕЗ 0.9 тэрбум төгрөгөөр/;
- Анхан шатны баримтын бүрдэл дутуу ажил гүйлгээг бүртгэл тайланд тусгасан; /ЭХЯ 1.3 тэрбум, ОНТЕЗ 0.1 тэрбум төгрөг/;
- Данс бүртгэлд 0.5 тэрбум авлагыг бүртгээгүй /Шадар сайд 0.1 тэрбум, ЗТХЯ 0.05 тэрбум, ЭМЯ 0.06 тэрбум, ОНТЕЗ 0.3 тэрбум төгрөг/;
- Орон нутгийн ТЕЗ-дын тайланд эзэн холбогдогч тодорхойгүй 0.06 тэрбум төгрөгийн найдваргүй авлага тайлагнасан.

Төрийн болон орон нутгийн өмчийн хуулийн этгээдийн авлага

Авлагын эхний үлдэгдэл 1,691.4 тэрбум, эцсийн үлдэгдэл 2,062.9 тэрбум болж, 371.5 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №18. Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн авлага /сая төгрөг/

Өмчийн хэлбэр	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Төрийн өмчит хуулийн этгээд	1,645,637.0	1,973,890.7	328,253.7
Орон нутгийн өмчит хуулийн этгээд	45,777.9	89,005.2	43,227.3
Дүн	1,691,414.9	2,062,895.9	371,481.0

Эх сурвалж: Засгийн газрын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой хуулийн этгээдийн авлагын үлдэгдэлд Сангийн яам 1,270.4 тэрбум, УУХҮЯ 294.0 тэрбум, БХБЯ 151.7 тэрбум, ОНӨҮГ 89.0 тэрбум, бусад ТӨҮГ 257.8 тэрбум төгрөгийг эзэлж байна.

Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн авлагын өсөлт нь Эрдэнэс Тавантолгой ХК-ийн борлуулалтын авлага 173.3 тэрбум, Монгол Улсын Хөгжлийн банкны авлага 81.3 тэрбум, шинээр байгуулагдсан Таван толгой ХК, Гүний ус ХК 26.3 тэрбум, Алтай орон сууцны корпораци ААТҮГ-ын 6.6 тэрбум төгрөг тус тус голлон нөлөөлсөн байна.

Нийгмийн даатгалын сангийн авлага

Нийгмийн даатгалын сангийн авлагын эхний үлдэгдэл 126.5 тэрбум, эцсийн үлдэгдэл 251.4 тэрбум болж, 124.9 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №19. Авлагын дансны үлдэгдэл, байгууллагын төрлөөр /сая.төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт(+), Бууралт(-)	Дүнд эзлэх хувь
Төлбөртэй үйлчилгээний авлага	117,011.6	138,273.0	21,261.4	55.0
Татаас, санхүүжилтийн авлага	5.1	-	(5.1)	-
Байгууллагаас авах авлага	9,455.8	113,072.0	103,616.2	45.0
Хувь хүмүүсээс авах авлага	16.8	66.3	49.5	0.0
Дүн	126,489.3	251,411.3	124,922.0	100

Эх сурвалж: Нийгмийн даатгалын сангийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд даатгалын шимтгэлийн дутуу төлөлт 21.3 тэрбум, татан буугдсан Капитал банкны эрх хүлээн авагчаас авах 103.6 тэрбум төгрөгөөр авлага өссөн байна.

Аудитын илрүүлэлт:

- Тооцоо нийлж баталгаажуулаагүй авлагын үлдэгдэл 1.1 тэрбум төгрөг /Булган 0.4 тэрбум, СБД 0.7 тэрбум/;
- Тооцоо нийлсэн актаас зөрүүтэй болон санхүүгийн тайланд бүртгээгүй авлага 1.9 тэрбум төгрөг /Дорноговь 1.2 тэрбум, СБД 0.6 тэрбум, Төв 0.2 тэрбум/;
- Олон жил болсон 4.0 тэрбум төгрөгийн авлагыг барагдуулаагүй /Дорнод 0.4 тэрбум, Говьсүмбэр 3.6 тэрбум/

Эрүүл мэндийн даатгалын сангийн авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 7.0 тэрбум, эцсийн үлдэгдэл 172.4 тэрбум болж, 165.4 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №20. Авлагын үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Төлбөртэй үйлчилгээний авлага	1.6	-	-1.6	-
Татаас, санхүүжилтийн авлага	6,715.8	26,529.8	19,814.0	15.4
Бусад авлага	305.9	145,845.2	145,539.3	84.6
Дүн	7,023.3	172,375.0	165,351.7	100.0

Эх сурвалж: Эрүүл мэндийн даатгалын сангийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Банкны эрх хүлээн авагч татан буугдсан Капитал банканд байршиж байсан харилцах, хадгаламжийн мөнгөн хөрөнгийн нэхэмжлэлийг 136.1 тэрбум төгрөгөөр баталгаажуулж, авлагын дансанд бүртгэсэн нь нийт авлагын дансны 75.0 хувийг эзэлж байна.

Аудитын илрүүлэлт:

- Эрүүл мэндийн даатгалын сангийн ХНХЯ-аас авах төр төлбөрийг нь хариуцах иргэдийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний зардлын 26.5 тэрбум төгрөгийн авлагыг тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.

Дөрөв. УРЬДЧИЛГАА

Урьдчилгаа дансны эхний үлдэгдэл 465.0 тэрбум, эцсийн үлдэгдэл 1,186.4 тэрбум болж, 721.4 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №21. Урьдчилгаа данс байгууллагын төрлөөр /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Төсөвт байгууллага	202,346.7	290,965.2	88,618.5	24.5
Төрийн сан	64,995.2	64,995.2	-	5.5
ТӨҮГ болон ОНӨҮГ	182,292.4	763,034.0	580,741.6	64.3
Төсөл/сан	15,377.4	67,445.0	52,067.6	5.7
Дүн	465,011.7	1,186,439.4	721,427.7	100.0

х сурвалж: Засгийн газрын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд Тавантолгой төмөр зам ХХК-ийн Таван толгой Гашуун сухайт чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалттай холбоотой 260.5 тэрбум, Монголын төмөр зам ТӨХК-ийн Таван толгой Зүүнбаян чиглэлийн төмөр зам барих төслийн барилгын ажлын 211.8 тэрбум төгрөгийн урьдчилгаа төлбөрийг нэмж бүртгэсэн нь өсөлтөд голлон нөлөөлсөн байна.

Аудитын илрүүлэлт:

- ЗТХЯ 0.5 тэрбум төгрөгийн урьдчилгааг тооцоо нийлж баталгаажуулаагүй;
- Урьдчилгаа төлбөрийн ажлын гүйцэтгэл хангалтгүйгээс 17.6 тэрбум төгрөгийг тайлант онд зардлаар хүлээн зөвшөөрч бүртгээгүй; /УУХҮЯ 16.8 тэрбум, ХХААХҮЯ 0.2 тэрбум, МИАТ ТӨХК 0.1 тэрбум, Ховд 0.3 тэрбум, Өвөрхангай 0.2 тэрбум/
- Он дамжсан 65.3 тэрбум төгрөгийн урьдчилгаа бүртгэлтэй; /Төрийн сан 65.0 тэрбум, БОАЖЯ 0.3 тэрбум, ЭМДС 0.02 тэрбум/
- Урьдчилгаа төлбөрийн 0.1 тэрбум төгрөгийг зардалд бүртгэсэн. /ХЗДХЯ 0.1 тэрбум, ЗТХЯ 0.03 тэрбум/

Тав. БАРАА МАТЕРИАЛ

Бараа материалын эхний үлдэгдэл 1,564.0 тэрбум, эцсийн үлдэгдэл 2,039.5 тэрбум болж, 475.5 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №22. Бараа материал данс байгууллагын төрлөөр /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
ТӨҮГ болон ОНӨҮГ	785,648.0	1,261,577.7	475,929.7	61.8
Төсөвт байгууллага	774,398.1	772,614.4	-1,783.7	37.9
Төсөл/сан	3,969.7	5,310.2	1,340.5	0.3
Дүн	1,564,015.8	2,039,502.3	475,486.5	100.0

Эх сурвалж: Засгийн газрын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой хуулийн этгээдийн бараа материалын өсөлт нь шинээр нэгтгэгдсэн байгууллагуудтай холбоотой байна. Үүнд: Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ 289.0 тэрбум, Монголросцветмет ТӨҮГ 38.0 тэрбум, Багануур ХК 30.4 тэрбум, Таван толгой ХК 17.8 тэрбум төгрөг.

Улсын болон орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдын санхүүгийн нэгтгэсэн тайланд бараа материалтай холбоотой нийт 15.8 тэрбум төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн байна.

Аудитын илрүүлэлт:

- Худалдан авах ажиллагаатай холбоотой зөрчил 5.3 тэрбум төгрөг; /ЗТХЯ 0.6 тэрбум, ШС 0.2 тэрбум, ЭХЯ 0.2 тэрбум, Нийслэл 2.1 тэрбум, Говь-Алтай 1.4 тэрбум, Булган 0.4 тэрбум, Сэлэнгэ 0.2 тэрбум/
- Бараа материалын дансны ангилал буруу бүртгэсэн, үр ашиггүй зарцуулсан, шууд зардалд тусгасан анхан шатны баримтын бүрдэл дутуу зэрэг бүртгэл тайлагналтай холбоотой 10.5 тэрбум төгрөг; /ЭМЯ 1.4 тэрбум, ЭХЯ 1.1 тэрбум, УУХҮЯ 0.8 тэрбум, НДС 0.6 тэрбум, ХЗДХЯ 0.5 тэрбум, БХЯ 0.4 тэрбум, Нийслэл 0.7 тэрбум, Баян-Өлгий 0.6 тэрбум, Дорнод 0.3 тэрбум, Сүхбаатар 0.3 тэрбум, Орхон 0.3 тэрбум/;

Зургаа. БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ

Бусад эргэлтийн хөрөнгийн эхний үлдэгдэл 2,698.8 тэрбум, эцсийн үлдэгдэл 5,109.9 тэрбум болж, 2,411.1 тэрбум төгрөгөөр өссөн байна. Үүнээс улсын төсвийн ерөнхийлөн захирагчид 2,374.4 тэрбум, орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчид 36.7 тэрбум төгрөг байна.

Аудитын илрүүлэлт:

- Бусад эргэлтийн хөрөнгө дансанд улсын комисс хүлээж аваагүй, гэрээнд заасан хугацаандаа ашиглалтад ороогүй, ТӨБЗГ-ын тогтоол гараагүй, төсөл хөтөлбөрийн үр дүнд бий болсон тоног төхөөрөмж, эд хөрөнгийг ашиглагч байгууллагуудад шилжүүлээгүй улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн төсөл, арга хэмжээний 1,735.0 тэрбум төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй;
- Концессоор хэрэгжсэн Сэлэнгэ аймгаар өнгөрөх Олон Улсын авто замтай холбох 95 км хатуу хучилттай авто зам барих төслийг санхүүжүүлсэн 57.2 тэрбум төгрөгийн хөрөнгийг эцэслэн шийдвэрлээгүй байна.

Долоо. УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

Урт хугацаат хөрөнгө оруулалт дансны эхний үлдэгдэл 6,930.0 тэрбум, эцсийн үлдэгдэл 8,540.9 тэрбум болж, 1,610.9 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №23. Урт хугацаат хөрөнгө оруулалт, байгууллагын төрлөөр /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Урт хугацаат хадгаламж	1,193,085.9	67,467.2	-1,125,618.7	0.8
Үнэт цаас	411,098.7	1,693,048.2	1,281,949.5	19.8
Урт хугацаат зээл	5,325,822.5	6,780,397.7	1,454,575.2	79.4
Дүн	6,930,007.1	8,540,913.1	1,610,906.0	100.0
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр харуулбал:</i>				
Төсөвт байгууллага	41,463.6	47,341.4	5,877.8	0.5
Төрийн сан	1,917,515.1	2,133,815.8	216,300.7	25.0
ТӨҮГ болон ОНӨҮГ	4,971,028.4	6,359,755.9	1,388,727.5	74.5
Дүн	6,930,007.1	8,540,913.1	1,610,906.0	100.0

Эх сурвалж: Засгийн газрын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Урт хугацаат хөрөнгө оруулалтын 25.5 хувь буюу 2,179.8 тэрбум төгрөг Засгийн газрын, 74.5 хувь буюу 6,359.7 тэрбум төгрөг төрийн өмчит болон өмчийн оролцоотой хуулийн этгээдийн хадгаламж, үнэт цаас, урт хугацаат зээлээрх хөрөнгө оруулалт байна.

Засгийн газрын урт хугацаат хөрөнгө оруулалт өмнөх оноос 220.8 тэрбум төгрөгөөр өссөн байна. Үүнд: ОУВС-д оруулсан хувь оролцоо, зээл ханшийн өөрчлөлтөөр 86.6 тэрбум, давуу эрхтэй ипотекийн зээлээр баталгаажсан бонд 98.7 тэрбум, Төрийн банкны дүрмийн санд оруулсан хөрөнгө оруулалт 20.9 тэрбум, Капитал банкны эзэмшиж байсан бондыг ЖДҮХС-аас авах авлагад суутган тооцож Засгийн газрын эзэмшилд шилжүүлсэн энгийн эрхтэй бонд 10.4 тэрбум, Азийн дэд бүтцийн хөрөнгө оруулалтын банкны хувь нийлүүлсэн хөрөнгө 4.5 тэрбум төгрөг.

Төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой хуулийн этгээдийн хөрөнгө оруулалт өмнөх оноос 1,388.7 тэрбум төгрөгөөр өссөн байна. Үүнд: Төрийн өмчийн 51 ба түүнээс дээш хувийн оролцоотой аж ахуйн нэгжүүдийн санхүүгийн тайланг нэгтгэгдсэнээс 7.8 тэрбум, Хөшгийн хөндийн нисэх онгоцны шинэ буудалд оруулсан 35.3 тэрбум, Тавантолгой төмөр зам ХХК, Эрдэнэс Тавантолгой майнинг ХХК-д оруулсан 311.7 тэрбум, Оюу толгой ХК-ийн нэмж гаргасан 58.3 сая ширхэг хувьцааны 583.8 тэрбум төгрөгийг Эрдэнэс оюу толгой ХХК нэмж бүртгэсэн, Монгол Улсын Хөгжлийн банкны хадгаламж 2.1 тэрбум, үнэт цаас 38.6 тэрбум, хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдэд олгосон урт хугацаат зээл 466.1 тэрбум, Үндэсний давхар даатгал ХХК-ийн мөнгөн хадгаламж 3.1 тэрбум, Хөвсгөл аймгийн Сум хөгжүүлэх сангаас 2 жилээс дээш хугацаагаар олгосон зээлийн 1.3 тэрбум төгрөг.

Аудитын илрүүлэлт:

- Урт хугацаат хөрөнгө оруулалтыг хадгаламж, үнэт цаас, урт хугацаат зээлээр ангилж бүртгэхдээ санхүүгийн хөрөнгийн шинж чанар, зориулалтыг харгалзахгүй бүртгэсэн;
- Сум хөгжүүлэх сангаас хувь хүмүүст олгож байгаа 2 ба түүнээс дээш жилийн хугацаатай зээлийг Хөвсгөл аймгаас бусад аймаг, нийслэл, сум, дүүргийн санхүүгийн тайланд урт ба богино хугацаат хөрөнгө оруулалт дансанд тайлагнаагүй, авлагаар бүртгэсэн;
- Сангийн сайдын санхүүгийн нэгтгэсэн тайланд бүртгэлтэй урт хугацаат хөрөнгө оруулалт дансанд бүртгэлтэй Малын индексжүүлсэн даатгалын алдагдал зогсоох сангийн эх үүсвэр 8.5 тэрбум төгрөг Үндэсний давхар даатгал ХХК-ийн дүрмийн сангаас 5.0 тэрбум төгрөгөөр зөрүүтэй;
- Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын охин компаниудад оруулсан хөрөнгө оруулалт 7.3 тэрбум төгрөг урт хугацаат хөрөнгө оруулалтыг хадгаламж дансанд бүртгэсэн;
- Эрдэнэс Тавантолгой ХХК Засгийн газрын 2018 оны 73, 2019 оны 296 дугаар тогтоолуудыг үндэслэн Эрдэнэс Тавантолгой майнинг ХХК-ийг үүсгэн байгуулж 2.8 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн боловч Засгийн газрын 2020 оны 146 дугаар тогтоолоор 296 дугаар тогтоол хүчингүй болж, үйл ажиллагааг зогсоосон;
- ТОСК ХХК-ийн охин компани үйл ажиллагаа явуулаагүй, Батлан хамгаалах аж үйлдвэрийн нэгдлийн Монгол цэрэг жуулчин ХХК-д оруулсан хөрөнгө оруулалт шүүхийн маргаантай, Худалдаа үйлдвэрлэлийн их сургуулийн Сүхбаатар хөлөг онгоцонд оруулсан хөрөнгө

оруулалтын хувьцааны эзэмшигч маргаантай, Далайн захиргаа УТҮГ-ын хөрөнгө оруулсан Монгол саммок ложистик ХХК үйл ажиллагаа явуулж эхлээгүй зэрэг 0.4 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт байна.

Найм. ҮНДСЭН ХӨРӨНГӨ

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл цэвэр дүнгээр 35,152.9 тэрбум, эцсийн үлдэгдэл 37,653.0 тэрбум болж, 2,500.1 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна.

Хүснэгт №24. Үндсэн хөрөнгө дансны ангилал, байгууллагын төрлөөр /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Газар	33,357.1	33,357.1	-	0.1
Биет хөрөнгө	18,972,094.1	20,971,129.2	1,999,035.1	55.7
Биет бус хөрөнгө	15,342,471.1	15,388,675.6	46,204.5	40.9
Бусад хөрөнгө	805,021.1	1,259,837.7	454,816.6	3.3
Дүн	35,152,943.4	37,652,999.6	2,500,056.2	100.0
<i>Үүнээс байгууллагын төрлөөр</i>				
ТӨҮГ болон ОНӨҮГ	18,497,736.4	22,656,941.7	4,159,205.3	60.2
Төсөвт байгууллага	16,487,351.8	14,460,886.9	-2,026,464.9	38.4
Төсөл/сан	167,855.2	535,171.0	367,315.8	1.4
Дүн	35,152,943.4	37,652,999.6	2,500,056.2	100.0

Эх сурвалж: Засгийн газрын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Улсын төсвийн ерөнхийлөн захирагчид 2,217.7 тэрбум, орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчид 282.4 тэрбум төгрөгөөр нэмэгджээ.

Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ, Монголросцветмет ТӨҮГ, Тавантолгой төмөр зам ХХК, Эрдэнэс Таван толгой майнинг ХХК, Эрдэнэс силвер ресурс ХХК, Багануур ХК-ийн санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс хөрөнгө өссөн байна.

Улсын болон орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдын санхүүгийн нэгтгэсэн тайланд үндсэн хөрөнгөтэй холбоотой нийт 377.2 тэрбум төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн байна.

Аудитын илрүүлэлт:

- Засгийн газрын гадаад зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй төслийн хүрээнд бий болсон **338.6** тэрбум төгрөгийн хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй. /Нийслэл 5 төслийн 252.8 тэрбум, БСШУСЯ 2 төслийн 74.7 тэрбум, ХНХЯ 6.5 тэрбум/
- Худалдан авах ажиллагааны тухай хууль тогтоомжийг зөрчиж нийт 7.6 тэрбум төгрөгийн хөрөнгө бэлтгэсэн. Тухайлбал: ХЗДХЯ 1.0 тэрбум, ШС 0.6 тэрбум, ЗТХЯ 0.3 тэрбум, УУХҮЯ 0.3 тэрбум, Нийслэл 2.7 тэрбум, Дархан-Уул 1.5 тэрбум, Дорнод 0.2 тэрбум, Сүхбаатар 0.2 тэрбум.
- Үндсэн хөрөнгийн дансны ангилал буруу бүртгэсэн, үр ашиггүй зарцуулсан, зардалд тусгасан, анхан шатны баримтын бүрдэл дутуу зэрэг бүртгэл тайлагналтай холбоотой 31.0 тэрбум төгрөгийн зөрчил. Тухайлбал: БХЯ 9.7 тэрбум, ХНХЯ 0.6 тэрбум, БХБЯ 3.3 тэрбум, ЭМЯ 1.1 тэрбум, ХЗДХЯ 0.9 тэрбум, Нийслэл 1.9 тэрбум, Өвөрхангай 2.4 тэрбум, Хөвсгөл 1.9 тэрбум, Дундговь 1.4 тэрбум, Ховд 1.1 тэрбум, Дархан-Уул 1.1 тэрбум.

Дуусаагүй барилга, байгууламж

Дуусаагүй барилга, байгууламж дансны эхний үлдэгдэл цэвэр дүнгээр 2,083.0 тэрбум, эцсийн үлдэгдэл 1,064.5 тэрбум болж, 1,018.5 тэрбум төгрөгөөр буурсан байна.

Барьж дууссан барилга байгууламжийг улсын комиссын акт гараагүй, ашиглагч байгууллагад шилжүүлэх тогтоол шийдвэргүй зэрэг шалтгаанаар дуусаагүй барилга дансанд бүртгэлтэй байгаа нь ашиглаж байгаа хөрөнгөд элэгдэл тооцогдохгүй, тайлант үеийн зардал дутуу илэрхийлэгдэхэд нөлөөлж байна.

Дуусаагүй барилга, байгууламж дансанд улсын болон орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдын 3-аас дээш жилийн насжилттай 117.0 тэрбум төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй байна.

Аудитын илрүүлэлт:

- УТЕЗ: Барилга байгууламжийг хүлээж авах улсын комиссын акт гараагүй, ашиглагч байгууллагад шилжүүлэх тогтоол шийдвэргүй, гүйцэтгэгч компанитай санхүүгийн асуудлаар маргаантай дуусаагүй барилга 59.9 тэрбум төгрөг. Тухайлбал:ЗТХЯ 21.0 тэрбум, ХНХЯ 7.0 тэрбум, ЭХЯ 6.5 тэрбум, ГХЯ 5.2 тэрбум, ЭМЯ 4.6 тэрбум, БХЯ 3.2 тэрбум, БСШУСЯ 4.8 тэрбум, ШС 2.9 тэрбум, УУХҮЯ 2.2 тэрбум.
- ОНТЕЗ: Санхүүжилт зогссон, санхүүжилтийн эх үүсвэр батлагдаагүй, өмчлөлийн маргаантай, гүйцэтгэгч ажлаа дуусгаагүй, улсын комисс хүлээж аваагүй дуусаагүй барилга 57.1 тэрбум төгрөг. Тухайлбал: Дархан-Уул аймаг 9.2 тэрбум, Өмнөговь аймаг 4.9 тэрбум, Сэлэнгэ аймаг 2.8 тэрбум, Дундговь аймаг 2.2 тэрбум, Дорнод аймаг 7.9 тэрбум, Сүхбаатар аймаг 2.4 тэрбум.

Ес. ӨР ТӨЛБӨР

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 29,798.4 тэрбум, эцсийн үлдэгдэл 33,178.6 тэрбум болж, 3,380.2 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №25. Нийт өр, төлбөр дансны ангилал, байгууллагын төрлөөр /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн (+), Буурсан (-)	Дүнд эзлэх хувь
Богино хугацаат өр төлбөр дүн	3,016,665.8	3,521,882.4	505,216.6	10.6
Богино хугацаат үнэт цаас	77,254.8	15,575.3	-61,679.5	0.1
Богино хугацаат зээлийн өглөг	1,362,191.6	1,441,547.7	79,356.1	4.3
Өглөг	1,181,540.6	1,591,091.0	409,550.4	4.8
Урьдчилж орсон орлого	395,678.8	473,668.4	77,989.6	1.4
Урт хугацаат өр төлбөр дүн	26,781,780.7	29,656,813.6	2,875,032.9	89.4
Урт хугацаат үнэт цаас	12,350,655.7	12,695,201.0	344,545.3	38.3
Урт хугацаат зээл	14,431,125.0	16,961,612.6	2,530,487.6	51.1
Нийт дүн	29,798,446.5	33,178,696.0	3,380,249.5	100.0
Үүнээс, байгууллагын төрлөөр:				
Төрийн сан	21,526,445.3	23,227,009.2	1,700,563.9	70.0
ТӨҮГ болон ОНӨҮГ	7,782,161.0	9,314,463.3	1,532,302.3	28.1
Төсөвт байгууллага	409,606.9	368,351.6	-41,255.3	1.1
Төсөл/сан	80,233.3	268,871.9	188,638.6	0.8
Нийт дүн	29,798,446.5	33,178,696.0	3,380,249.5	100.0

Эх сурвалж: Засгийн газрын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Богино хугацаат үнэт цаасны үлдэгдэл буурсан нь Төрийн банк 61.7 тэрбум төгрөгийн өрийн бичиг төлсөнтэй холбоотой байна.

Богино хугацаат өр төлбөр 505.2 тэрбум төгрөгөөр, урт хугацаат өр төлбөр 2,875.0 тэрбум төгрөгөөр өссөн нь дараах шалтгаантай байна. Үүнд:

- Санхүүгийн нэгтгэсэн тайланд шинээр нэгтгэгдсэн Багануур ХК, Монголросцветмет ТӨҮГ-ын богино хугацаат зээлийн өглөг 83.6 тэрбум;
- Дансны өглөг төсөвт байгууллагуудын 141.6 тэрбум, УУХҮЯ-ны харьяа төрийн өмчит хуулийн этгээдийн 136.4 тэрбум;
- Урьдчилж орсон орлого шинээр нэгтгэгдсэн Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын 60.3 тэрбум, Монголросцветмет ТӨҮГ-ын 13.3 тэрбум, Монгол Улсын хилээр дамжин өнгөрч байгаа бараанд хуулийн дагуу ногдуулсан татварын буцаан олголт 11.5 тэрбум;
- Урт хугацаат гадаад бонд, зээлийн өр ханшийн өөрчлөлтөөр 662.2 тэрбум, гадаад зээлийн ашиглалтаар 1,638.6 тэрбум, төрийн болон орон нутгийн өмчийн хуулийн этгээдийн өр төлбөр 1,532.3 тэрбум төгрөг.

Гадаад эх үүсвэрээс хүү бага, урт хугацаатай зээл ашиглаж, хүүгийн зардал хэмнэж байгаа боловч сүүлийн 7 жилд гадаад бонд, зээлийн ханшийн зөрүүнээс нийт 5,776.3 тэрбум төгрөгийн алдагдал хүлээсэн нь ханшийн зөрүүгээр өр төлбөр нэмэгдэж, өрийн дарамтад орох сөрөг үр дагавартай байна.

Үнэт цаас, зээлийн өглөг

Нийт өр төлбөрийн 93.8 хувь буюу 31,113.9 тэрбум төгрөгийг үнэт цаас, зээлийн өглөг эзэлж байна.

Хүснэгт №26. Үнэт цаас, зээлийн өглөг /сая төгрөг/

Үнэт цаасны зориулалт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Засгийн газрын өр төлбөр дүн	21,237,569.7	22,981,556.6	1,743,986.9	73.9
Дотоод бонд	1,579,851.6	1,414,745.7	-165,105.9	4.6
Гадаад үнэт цаас, бондын өглөг	19,657,718.1	21,566,810.9	1,909,092.8	69.3
Гадаад бондын өглөг	7,682,575.7	7,945,315.7	262,740.0	25.5
ОУВС /үнэт цаас/	774,022.2	820,646.1	46,623.9	2.6
Гадаад зээл /хөнгөлөлттэй/	11,201,120.2	12,800,849.1	1,599,728.9	41.2
ТӨҮГ болон ОНӨҮГ-ын дүн	6,938,003.3	7,997,987.7	1,059,984.4	25.7
Үнэт цаасны өглөг	2,391,461.2	2,530,068.8	138,607.6	8.1
Зээлийн өглөг	4,546,542.1	5,467,918.9	921,376.8	17.6
Бусад байгууллагын зээлийн өглөг	45,654.2	134,392.2	88,738.0	0.4
Нийт дүн	28,221,227.1	31,113,936.5	2,892,709.4	100.0

Эх сурвалж: Засгийн газрын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын өр төлбөр 1,744.0 тэрбум, төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой хуулийн этгээдийн өр төлбөр 1,060.0 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Засгийн газрын үнэт цаас, зээл

Хүснэгт №27. Засгийн газрын бонд, гадаад зээлийн өглөг /сая төгрөг/

Үзүүлэлт	Дотоод бонд	Гадаад бонд	Гадаад зээл	Дүн
Нэмэгдсэн:		262,740.1	2,038,085.8	2,300,825.9
Зээлийн ашиглалт			1,638,599.5	1,638,599.5
Ханшийн алдагдал		262,740.1	399,486.3	662,226.4
Хасагдсан:	165,105.9		438,344.0	603,449.9
Үндсэн төлбөр	165,105.9		438,344.0	603,449.9
Хүүгийн төлбөр	185,753.2	507,683.2	167,544.6	860,981.0

Эх сурвалж: Засгийн газрын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын бонд, зээл нэмэгдсэн, хасагдсан шалтгаан. Үүнд:

- Тайлант онд олон улсын зах зээлд бонд арилжаалаагүй бөгөөд ханшийн алдагдлаар 262.7 тэрбум;
- Төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэхэд зориулан авсан гадаадын зээлийн ашиглалт 1,638.6 тэрбум, ханшийн алдагдал 399.5 тэрбум, нийт 2,038.1 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдсэн;
- Төсвийн дутагдлыг санхүүжүүлэх Засгийн газрын дотоод бондыг буцаан худалдан авсан 118.1 тэрбум, Хүний хөгжил сангийн бондын төлбөрт 47.0 тэрбум, нийт 165.1 тэрбум;
- Олон улсын байгууллагаас авсан урт хугацаат гадаад хөнгөлөлттэй зээлийн үндсэн төлбөрт 438.3 тэрбум төгрөгөөр тус тус хасагдсан байна.

Дотоод бондын хүү 185.7 тэрбум, гадаад бондын хүү 507.7 тэрбум, гадаад зээлийн хүү 167.5 тэрбум, нийт 860.9 тэрбум төгрөгийг төлсөн.

Аудитын илрүүлэлт:

- Гадаад зээлийн эх үүсвэрээс санхүүжсэн 226.3 тэрбум төгрөгийн 14 төсөлд эрсдэлийн үнэлгээ хийгээгүй, нийгэмд бий болох ач холбогдлоор нь эрэмбэлээгүй;
- Урт хугацаат дотоод бондын хөнгөлөлт 15.5 тэрбум төгрөгийг богино хугацаат өр төлбөрийн ангилалд бүртгэсэн;
- Гадаад зээлийн 23 төсөл, хөтөлбөрийн эх үүсвэрээс дамжуулан зээлдүүлсэн 649.5 тэрбум төгрөгийн зээлийн өглөгийг зээлдэгч 35 байгууллага санхүүгийн тайланд бүртгээгүй;

- Засгийн газрын 2006 оны 185 дугаар тогтоолоор баталсан "Гадаадын зээлийн хөрөнгийг дотоодод дамжуулан зээлдүүлэх журам"-ыг Өрийн удирдлагын тухай хууль болон Өрийн удирдлагын стратегийн баримт бичигтэй уялдуулан шинэчлэн баталж, мөрдөх өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй.

Төрийн өмчит хуулийн этгээдийн өр төлбөр

Төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой хуулийн этгээдийн өр төлбөрийн эхний үлдэгдэл 7,782.1 тэрбум, эцсийн үлдэгдэл 9,314.4 тэрбум төгрөг болж, 1,532.3 тэрбум төгрөгөөр өссөн. Өр төлбөрийн 2,530.0 тэрбум төгрөг нь үнэт цаас, 5,467.9 тэрбум төгрөг нь зээлийн өглөг, 1,316.5 тэрбум төгрөг нь бусад өглөг байна.

Төрийн өмчит хуулийн этгээдийн өр төлбөрийн үлдэгдэл. Тухайлбал:

Үнэт цаас: Монгол Улсын Хөгжлийн банкны 2,173.0 тэрбум, Монголын төмөр зам ТӨХК-ийн 357.0 тэрбум төгрөг;

Зээлийн өглөг: Төрийн банк 2,871.6 тэрбум, Монгол Улсын Хөгжлийн банк 973.7 тэрбум, Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ 161.1 тэрбум, Хадгаламж даатгалын корпораци 149.0 тэрбум, Дулааны цахилгаан станц 4 ТӨХК 154.7 тэрбум, Тавантолгой түлш ХХК 130.3 тэрбум, Ус сувгийн удирдах газар 103.1 тэрбум, Монголын төмөр зам ТӨХК 101.2 тэрбум, Багануур ХК 51.8 тэрбум, МИАТ ТӨХК 42.5 тэрбум, Монголросцветмет ТӨҮГ 31.7 тэрбум, Эрдэнэс Монгол ХХК 17.5 тэрбум, Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК 9.1 тэрбум төгрөг.

Монгол Улсын Хөгжлийн банк нь гадаад үнэт цаас болон өөрийн хөрөнгийн эх үүсвэрээс 2013-2019 онуудад 11 төрийн өмчит хуулийн этгээдэд олгосон 887.5 тэрбум төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байна.

Аудитын илрүүлэлт:

- Монгол Улсын Хөгжлийн банкнаас олгосон дараах зээлд эрсдэл үүссэн байна. Үүнд:
 - Самурай бондын эх үүсвэрээр санхүүжүүлсэн ТОСК ТӨҮГ 6.5 тэрбум, Чингис бондын эх үүсвэрээр санхүүжүүлсэн ЖДҮХС-ийн 10.0 тэрбум төгрөгийн зээлийн хугацаа хэтэрсэн;
 - ТЭДС-д олгосон 39.2 тэрбум төгрөгийн техникийн зээлийн эх үүсвэрээс иргэд, аж ахуйн нэгжид олгосон техникийн дамжуулан зээлийн 19.4 тэрбум төгрөгийн авлагын хугацаа хэтэрсэн;
 - Чингис бондын эх үүсвэрээс 40.0 тэрбум төгрөгөөр санхүүжүүлсэн Тавантолгойн цахилгаан станц төслийн үйл ажиллагаа зогсонги байдалтай, санхүүгийн тайлангаар 22.1 тэрбум төгрөгийн алдагдал хүлээж, зээлийн эргэн төлөлтөд эрсдэл үүссэн;
 - Банк зээл олгохдоо зээлдэгчийн санхүүгийн тайлан, бизнес төлөвлөгөө, борлуулалтад ирээдүйд бий болох эрсдэлийг тооцоолоогүй нь зээлийн эргэн төлөлт удаашрах, чанаргүй зээл нэмэгдэх, улмаар банкны санхүүгийн үйл ажиллагаанд хүндрэл учрах эрсдэлтэй;
- Төрийн банк нь аж ахуйн нэгжид зээл олгохдоо зээлийн барьцаанд ирээдүйд орох орлогыг 100 хувиар тооцсон;
- Төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой 151 хуулийн этгээд мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй боловч 163.7 тэрбум төгрөг татвар, НДШ-ийн өглөгийг барагдуулаагүй байна.

Төсөвт байгууллагын өр төлбөр

Төсөвт байгууллагын өр төлбөрийн эхний үлдэгдэл 409.6 тэрбум, эцсийн үлдэгдэл 368.3 тэрбум болж, 41.2 тэрбум төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №28. Төсвийн байгууллагын өр, төлбөр /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн (+), Буурсан (-)	Дүнд эзлэх хувь
<i>Богино хугацаат өр төлбөр дүн</i>	380,297.5	347,981.1	-32,316.4	94.5
Богино хугацаат зээлийн өглөг	57.7	57.3	-0.4	0.0
Өглөг	318,149.3	280,684.2	-37,465.1	76.2
Урьдчилж орсон орлого	62,090.5	67,239.6	5,149.1	18.3
<i>Урт хугацаат өр төлбөр дүн</i>	29,309.5	20,370.6	-8,938.9	5.5
Нийт дүн	409,607.0	368,351.6	-41,255.3	100.0

Эх сурвалж: Засгийн газрын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

лсын ТЕЗ-дын өр төлбөр 80.5 хувь, орон нутгийн ТЕЗ-дын өр төлбөр 19.5 хувийг эзэлж байна.

Дансны өглөг 280.7 тэрбум төгрөгийн үлдэгдэл байна. Тухайлбал: ЗТХЯ 47.4 тэрбум, ХХААХҮЯ 39.7 тэрбум, ЭМЯ 28.8 тэрбум, БСШУСЯ 18.8 тэрбум, ХЗДХЯ 56.7 тэрбум, БХБЯ 12.9 тэрбум, ЕС 10.0 тэрбум, Өмнөговь аймгийн ТЕЗ 12.1 тэрбум төгрөг байна.

Үүнээс байгууллагад өгөх өглөг 18.7 тэрбум төгрөгөөр буурч, 202.1 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байна. Тухайлбал: Хөрөнгө оруулалтын барьцаа ЗТХЯ 47.4 тэрбум, ЭМЯ 26.4 тэрбум, БСШУСЯ 14.5 тэрбум, БХБЯ 12.9 тэрбум, нийт 101.2 тэрбум төгрөг, ТЭДС-ийн буудай, шатахууны өглөг 37.1 тэрбум төгрөг.

ХЗДХЯ-ны харьяа Банк хадгаламж зээлийн хоршооны төлбөр барагдуулах ажлын албаны өглөг 27.7 тэрбум, Цагдаагийн ерөнхий газрын Санхүү, хангамжийн газрын өглөг 11.3 тэрбум төгрөг нь хувь хүмүүст өгөх нийт 46.5 тэрбум төгрөгийн өглөгийн 83.9 хувийг эзэлж байна.

Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдын өр төлбөр

Өр төлбөрийн эхний үлдэгдэл 344.9 тэрбум, эцсийн үлдэгдэл 508.6 тэрбум болж, 163.7 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №29. Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдын өр төлбөр /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
<i>Богино хугацаат өр төлбөрийн дүн</i>	<i>173,880.4</i>	<i>249,591.5</i>	<i>75,711.1</i>	<i>49.1</i>
Богино хугацаат зээлийн өглөг	2,407.8	2,665.2	257.4	0.5
Богино хугацаат өглөг	125,531.9	165,203.5	39,671.6	32.5
Урьдчилж орсон орлого	45,940.7	81,722.8	35,782.1	16.1
<i>Урт хугацаат зээл</i>	<i>171,026.4</i>	<i>258,975.5</i>	<i>87,949.1</i>	<i>50.9</i>
Нийт дүн	344,906.8	508,567.0	163,660.2	100.0

Эх сурвалж: Засгийн газрын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Өр төлбөр өмнөх оноос өссөн нь дараах шалтгаантай байна. Тухайлбал:

- Орон нутгийн өмчит 32 хуулийн этгээдийн урт хугацаат зээл өмнөх оноос 77.6 тэрбум төгрөгөөр;
- Тайлант онд ТЕЗ-дын санхүүгийн нэгтгэсэн тайланд шинээр нэгтгэгдсэн болон байгуулагдсан 14 орон нутгийн өмчит хуулийн этгээдийн богино хугацаат өглөг 30.3 тэрбум, урьдчилж орсон орлого 29.0 тэрбум, урт хугацаат зээл 10.0 тэрбум, нийт 69.3 тэрбум төгрөг нэмж бүртгэсэн.

Нийслэл, 19 аймгийн харьяа 51 аж ахуйн нэгж, байгууллагад хэрэгжүүлж байгаа Азийн хөгжлийн банкны 14, Дэлхийн банкны 4, Хөдөө аж ахуйг хөгжүүлэх олон улсын сангийн 1, Франц улсын 1, Испани улсын 1, Солонгос улсын 1, нийт 22 төсөл, хөтөлбөрийн дамжуулан зээлийн авлага 468.5 тэрбум төгрөг байна.

Аудитын илрүүлэлт:

- Орон нутагт дамжуулан зээлдүүлсэн зээлийн 221.5 тэрбум төгрөгийн өр төлбөрийг 15 зээлдэгч санхүүгийн тайландаа тусгаагүй;
- Дамжуулан зээлдүүлэх 42 гэрээгээр 1994-2014 онд байгуулсан орон сууц, нийтийн аж ахуйн салбарт зориулан олгосон 260.1 тэрбум төгрөгийн зээлийн хугацаа хэтэрсэн, эргэн төлөлт хийгдээгүй.

Нийгмийн даатгал, Эрүүл мэндийн даатгалын сангийн өр төлбөр

Нийгмийн даатгалын сангийн өр төлбөр 21.0 тэрбум болж, 1.7 тэрбум төгрөгөөр буурсан байна. Өр төлбөрийн үлдэгдэлд богино хугацаат өр төлбөр 12.9 тэрбум, урьдчилж орсон орлого 8.1 тэрбум төгрөг байна.



рүүл мэндийн даатгалын сангийн өр төлбөрийн эхний үлдэгдэл 4.6 тэрбум, эцсийн үлдэгдэл 2.7 тэрбум болж, 1.9 тэрбум төгрөгөөр буурсан ба төр хариуцах иргэдийн эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн санхүүжилттэй холбоотой ХНХЯ-нд өгөх 2.5 тэрбум, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, бусад зардлын 0.2 тэрбум төгрөгийн өглөгийн үлдэгдэлтэй байна.

Арав. ЗАСГИЙН ГАЗРЫН ХУВЬ ОРОЛЦОО

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 26,972.4 тэрбум, эцсийн үлдэгдэл 34,017.1 тэрбум болж, 7,044.7 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №30. Засгийн газрын хувь оролцоо /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Засгийн газрын оруулсан капитал	5,925,949.1	7,645,981.1	1,720,032.0	22.5
Өмч	14,889,741.5	14,659,401.7	-230,339.8	43.1
Нэмж төлөгдсөн капитал	28,956.6	43,222.8	14,266.2	0.1
Эздийн өмчийн бусад хэсэг	4,482,252.8	5,214,618.8	732,366.0	15.3
Хуримтлагдсан үр дүн	-5,092,235.4	-658,022.3	4,434,213.1	-1.9
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	6,737,722.7	7,111,898.6	374,175.9	20.9
<i>Засгийн газрын хувь оролцооны дүн</i>	<i>26,972,387.3</i>	<i>34,017,100.7</i>	<i>7,044,713.4</i>	<i>100.0</i>
Хяналтын бус хувь оролцоо		4,676.2	4,676.2	0.0
Нийт дүн	26,972,387.3	34,021,776.9	7,049,389.6	100.0

Эх сурвалж: Засгийн газрын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо 7,044.7 тэрбум төгрөгийн өсөлтөд 51-ээс дээш хувийн оролцоотой болон шинээр байгуулагдсан хуулийн этгээдүүд нэгтгэгдэж 3,037.1 тэрбум, зарим төрийн өмчит хуулийн этгээдийн хөрөнгө нэмэгдсэн нь голлон нөлөөлсөн байна. Тухайлбал: Хөшгийн хөндийн нисэх онгоцны шинэ буудлын 1,317.2 тэрбум, Эрдэнэс оюу толгой ХХК хувьцаа 583.8 тэрбум, төсөл, сангийн 2,920.7 тэрбум төгрөг.

Төрийн өмчийн хувь оролцоо

Улсын төсвийн ерөнхийлөн захирагчдын засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 19,699.2 тэрбум, эцсийн үлдэгдэл 26,295.3 тэрбум болж, 6,596.1 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Засгийн газрын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн 159 /ИНЕГ-ын нисэх буудлуудын удирдах газрын харьяа 18 нисэх буудал/ төрийн өмчит хуулийн этгээдээс 3 хуулийн этгээд үйл ажиллагаа явуулаагүй байна.

Өмнөх оны аудитын зөвлөмжийн дагуу төрийн өмчийн 51-ээс дээш хувийн оролцоотой 9, орон нутгийн өмчөөс төрийн өмчид шилжсэн 1 хуулийн этгээдийн санхүүгийн тайланг нэмж нэгтгэсэн байна.

Тайлант онд 81 аж ахуйн нэгж, байгууллага 1,990.0 тэрбум төгрөгийн ашигтай, 75 аж ахуйн нэгж, байгууллага 143.9 тэрбум төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Орон нутгийн өмчийн хувь оролцоо

Орон нутгийн ТЕЗ-дын цэвэр хөрөнгө өмчийн дансны эхний үлдэгдэл 7,273.2 тэрбум, эцсийн үлдэгдэл 7,721.8 тэрбум болж, 448.6 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Орон нутгийн өмчит 390 хуулийн этгээдээс 5 байгууллага татан буугдаж, 1 байгууллага төрийн өмчид шилжсэн байна. Үүнээс 131 байгууллага 56.4 тэрбум төгрөгийн ашигтай, 233 байгууллага 231.1 тэрбум төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Аудитын илрүүлэлт:

- Засгийн газрын оруулсан капитал, төрийн болон хувийн өмч, нэмж төлөгдсөн капитал данснуудыг 77.4 тэрбум төгрөгөөр дансны ангилал хооронд зөрүүлэн бүртгэсэн.



рван нэг. Төсвийн ерөнхийлөн захирагчдын санхүүгийн тайланд хийсэн аудитын дүн

Улсын төсвийн ерөнхийлөн захирагчдын санхүүгийн тайлангийн аудит

Улсын төсвийн 33 ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийж Зөрчилгүй 26, Хязгаарлалттай 7 дүгнэлт /БСШУСС, ХНХС, УУХҮС, ЗТХС, ҮАБЗ, Нийгмийн даатгалын сан, Эрүүл мэндийн даатгалын сан/ өгсөн байна.

Аудитаар нийт 6,096.5 тэрбум төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 3,119.7 тэрбум төгрөгийн алдааг залруулж, 16.0 тэрбум төгрөгийн зөрчилд 428 төлбөрийн акт тогтоож, 303.9 тэрбум төгрөгийн зөрчилд 678 албан шаардлага, 24.1 тэрбум төгрөгийн 10 асуудлыг хууль хяналтын байгууллагад шилжүүлж, 8 албан тушаалтанд хариуцлага тооцуулах санал хүргүүлж, 2,657.0 тэрбум төгрөгийн алдаа, зөрчилд 2,449 зөвлөмж өгсөн.

Тайлант онд улсын төсвийн 33 ерөнхийлөн захирагчийн харьяа төсөвт байгууллага 998, ТӨҮГ 159, төсөл, хөтөлбөр 134, Засгийн газрын тусгай сан 22, нийт 1313 байгууллагын санхүүгийн тайланг аудитад хамруулж, 1155 байгууллагын санхүүгийн тайланд дүгнэлт өгсөн. Үүнээс Зөрчилгүй 1048, Хязгаарлалттай 99, Сөрөг 5, Татгалзсан 3.

Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдын санхүүгийн тайлангийн аудит

Орон нутгийн 22 төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар Зөрчилгүй 21, Булган аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд Хязгаарлалттай дүгнэлт өгсөн байна.

Аудитаар нийт 593.0 тэрбум төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 458.2 тэрбум төгрөгийн алдааг залруулж, 4.1 тэрбум төгрөгийн 1205 төлбөрийн акт тогтоож, 66.4 тэрбум төгрөгийн зөрчилд 1758 албан шаардлага, 64.3 тэрбум төгрөгийн алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх 4537 зөвлөмж өгч, үүнээс 0.4 тэрбум төгрөгийн 16 асуудлыг шалгуулахаар хууль хяналтын байгууллагад шилжүүлж, 435 албан тушаалтанд хариуцлага тооцуулах санал хүргүүлжээ.

Төрийн өмчит хуулийн этгээдийн санхүүгийн тайлангийн аудит

Төрийн өмчит 159 хуулийн этгээдээс 2 байгууллагад итгэл үзүүлж, 157 байгууллага аудитад хамрагдахаас аудит хийгдээгүй 4, үүнээс түүвэрт 9, Зөрчилгүй 123, Хязгаарлалттай 19, Сөрөг 1, Дүгнэлт өгөхөөс татгалзсан 1 дүгнэлт өгсөн байна.

Аудитаар нийт 1,891.0 тэрбум төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 466.3 тэрбум төгрөгийн алдааг залруулж, 0.7 тэрбум төгрөгийн зөрчилд 51 акт тогтоож, 10.9 тэрбум төгрөгийн зөрчилд 108 албан шаардлага, 1,413.1 тэрбум төгрөгийн зөрчилд 488 зөвлөмж өгч 2 албан тушаалтанд хариуцлага тооцуулах санал хүргүүлэв.

Хүснэгт №31. Өөрчлөлттэй дүгнэлттэй байгууллагууд

Хязгаарлалттай дүгнэлт:	12. Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨҮГ
1. Монгол Ус ТӨААТҮГ	13. Багануур тоосго ТӨҮГ
2. Бөртэ ТӨААТҮГ	14. Чингис хаан олон улсын нисэх буудал
3. Хөнгөн үйлдвэрлэлийн судалгаа туршилт, үйлдвэрлэл, бизнесийн корпораци	15. Нисэх буудлуудын удирдах газар
4.Автотээврийн үндэсний төв ТӨҮГ	16. Хэрэмт цамхаг УТҮГ
5. Монголын төмөр зам ТӨХК	17. Хөдөө аж ахуйн бирж
6. Орхон АЗЗА ТӨХК	18. Диспетчерийн үндэсний төв ХХК
7. Налайх АЗЗА ТӨХК	19. Эгийн голын усан цахилгаан станц ТӨХК
8. Баянчандмань АЗЗА ТӨХК	Сөрөг дүгнэлт:
9. Архангай АЗЗА ТӨХК	Дорнод их сургууль
10. Геологийн төв лаборатори ТӨҮГ	Дүгнэлт өгөхөөс татгалзсан:
11. Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ	Монгол Кувейтийн байгаль хамгаалах төв ТӨҮГ



айлант онд үйл ажиллагаа явуулаагүй 3, шинээр нэгтгэгдсэн Авто импекс ХХК-ийн санхүүгийн тайлан аудитад хамрагдаагүй байна.

Аудитын илрүүлэлт:

- Татан буугдах шийдвэр гарч үйл ажиллагаа явуулаагүй 3 хуулийн этгээдийн /Аялал жуулчлалын үндэсний төв ТӨҮГ, Авдарант хайрхан ТӨААТҮГ, Монгол тамга ТӨААТҮГ/ санхүүгийн тайлангийн хөрөнгө, авлага, өглөгийг шилжүүлж шийдвэрлээгүй;
- Авлага, өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй 2.9 тэрбум төгрөг / Монгол газрын тос боловсруулах үйлдвэр ХХК 1.3 тэрбум, Багануур ХК 0.6 тэрбум, Эрдэнэт-Булганы цахилгаан түгээх сүлжээ ХК 0.9 тэрбум, Эрчим хүчний хөгжлийн төв ТӨААТҮГ 0.1 тэрбум/
- Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулаагүй 0.8 тэрбум төгрөг /Автотээврийн үндэсний төв ТӨҮГ 0.2 тэрбум, Амгалан дулааны станц ХХК 0.1 тэрбум, Хэрэмт цамхаг УТҮГ 0.3 тэрбум, Буянт-ухаа дахь Чингис хаан Олон улсын нисэх буудал ТӨААТҮГ 0.2 тэрбум/
- Дулааны 4-р цахилгаан станц ТӨХК нь худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдаагүй 0.3 тэрбум төгрөгийн үндсэн хөрөнгө худалдаж авсан, их засварын зардлыг төлөвлөгөөнд заасан дүнгээс хэтрүүлэн зарцуулсан 0.6 тэрбум төгрөг;
- Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ нь эрх бүхий байгууллагын шийдвэргүйгээр 0.3 тэрбум төгрөгийн үндсэн хөрөнгө данснаас хассан, үр ашиггүй зарцуулсан 0.7 тэрбум төгрөг.

ЗГ-ын гадаад зээл, тусламжаар хэрэгжиж буй төслүүдийн санхүүгийн тайлангийн аудит

Монгол Улсын Засгийн газартай байгуулсан гэрээ хэлцлийн хүрээнд олон улсын 2 банк, санхүүгийн байгууллага болон 11 орны гадаадын зээл, тусламжийн 103 төсөл, арга хэмжээг 1,242.3 тэрбум, ОУВС-ийн өргөтгөсөн хөтөлбөрийн санхүүжилтээр 3 хөтөлбөрийг 578.5 тэрбум, нийт 1,820.8 тэрбум төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөж баталсан байна.

Хүснэгт №32. Төслийн санхүүжилтийн эх үүсвэр /сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан						
	Төлөвлөгөө		Гүйцэтгэл		Зөрүү		Хувь
	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	
Төслийн зээл	76	1,096,280.1	63	1,215,531.8	13	-119,251.7	110.9
Хөтөлбөрийн зээл	3	578,553.2	2	408,147.2	1	170,405.9	70.5
Тусламж	27	146,000.0	20	85,242.0	7	60,758.0	58.4
Дүн	106	1,820,833.3	85	1,708,921.1	21	111,912.2	93.9

Эх сурвалж: Монгол Улсын нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант онд зээлийн 63, буцалтгүй тусламжийн 20, хөтөлбөрийн 2, нийт 85 төсөл, хөтөлбөрт 1,708.9 тэрбум төгрөгийн санхүүжилтийг авсан байна.

Нийт 134 /Сангийн ямаар дамжин хэрэгжих 115, ТЕЗ-д хамаарах 19/ төсөл хөтөлбөрөөс Хараат бус аудитын хуулийн этгээд 67 санхүүгийн тайланд гэрээгээр аудит хийж Зөрчилгүй 59, Хязгаарлалттай 8 дүгнэлт өгч, аудитын түүвэрт 61 хамрагдаж, ашиглалт гараагүй 4, хэрэгжиж дууссан 2 төсөлд аудит хийгээгүй байна. Үүнд:

Хүснэгт № 33. Өөрчлөлттэй дүгнэлттэй сангууд

Хязгаарлалттай дүгнэлт:	Ашиглалт гараагүй:
Баруун бүсийн босоо тэнхлэгийн авто замыг хөгжүүлэх 2 дахь шатны төсөл	Газар тариалангийн үйлдвэрлэлд хөрс хамгаалах, өндөр хүчин чадлын дэвшилтэт технологийн тоног төхөөрөмж нийлүүлэх төсөл
Улаанбаатар хотын IV цахилгаан станцын үр ашгийг дээшлүүлэх төсөл	Хөдөө аж ахуйн трактор, механизм угсрах үйлдвэр байгуулах төсөл
Төсвийн санхүүгийн удирдлага ил тод, үр ашигтай байдал төсөл	Улаанбаатар хотын агаарын чанарыг сайжруулах хөтөлбөр
Хоршоолсон хэлбэрээр ногооны аж ахуй эрхлэх замаар өрхийн амьжиргааг сайжруулах төсөл	Төсөв, санхүүгийн тогтвортой байдлыг дэмжих төсөл-2
Хөдөлмөр эрхлэлтийн үр чадварыг дээшлүүлэх төсөл	Хэрэгжиж дууссан төсөл:
Үндэсний оношилгоо, эмчилгээний төв байгуулах төсөл	Монголын Статистикийн чадавхыг бэхжүүлэх төсөл
Боловсролын чанарын шинэчлэл	Монгол Улсын засаглалыг бэхжүүлэх төсөл
Бүс нутгийн авто зам хөгжүүлэх, засвар арчлалтын төсөл	



удитаар нийт 227.0 тэрбум төгрөгийн алдаа, зөрчил илрүүлж, аудитын явцад 132.5 тэрбум төгрөгийн алдааг залруулж, 0.01 тэрбум төгрөгийн 3 төлбөрийн акт тогтоож, 0.2 тэрбум төгрөгийн 10 албан шаардлага, 94.3 тэрбум төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 63 зөвлөмж хүргүүлээ.

Аудитын илрүүлэлт:

- Төсвийн тухай хуульд заасан цаглаварт хугацаанд санхүүгийн тайлан ирүүлээгүй /Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил төсөл, Баруун бүсийн босоо тэнхлэгийн авто замыг хөгжүүлэх 2 дахь шатны төсөл/;
- Тайлант хугацааны худалдан авалтыг НӨАТ-ын хэрэглэгчийн системтэй тулган шалгахад 92.1 тэрбум төгрөгийн худалдан авалт бүртгэгдээгүй, төлбөрийн баримт /э-баримт/-ыг анхан шатны баримтад бүрэн хавсаргаагүй нь харилцагч, бэлтгэн нийлүүлэгч байгууллагууд НӨАТ-ыг санхүүгийн болон татварын тайланд тусгахгүй байх, орлогоо нуун дарагдуулах боломжийг бүрдүүлсэн /Баруун бүсийн босоо тэнхлэгийн авто замыг хөгжүүлэх 2 дахь шатны төслийн нэгж 24.3 тэрбум, Хөдөлмөр эрхлэлтийн үр чадварыг дээшлүүлэх төсөл 15.9 тэрбум, Бүс нутгийн авто зам хөгжүүлэх, засвар арчлалтын төсөл 51.9 тэрбум төгрөг/;
- Бүс нутгийн авто зам хөгжүүлэх, засвар арчлалтын төслийн Хар модот давааны араас урьхан хүртэлх, Сүмбэрийн уулзвараас Цайдмын хөндий хүртэлх гүйцэтгэсэн ажлын үр дүн нь зээлийн гэрээн дэх ажлын төлөвлөгөө, олгосон санхүүжилтийн дүнтэй харьцуулахад хангалтгүй, гэрээнд заасан ажлыг хугацаандаа гүйцэтгээгүй;
- Төсөл хэрэгжүүлэх нэгжүүд байрны түрээсийн төлбөрийг ТӨБЗГ-аас баталсан түрээсийн төлбөрийн дээд хязгаараас өндөр болон 1 хүнд ноогдох талбайн хэмжээг төрийн албан хаагчдын ашиглах талбайн хэмжээнээс илүү талбай түрээслэдэг;
- Эм, эмнэлгийн бүтээгдэхүүнүүдийг захиалгын дагуу салбар хүлээн авагчдад хуваарилан түгээх үйл ажиллагаа удаашралтай, жилийн эцэст хуваарилагдаагүй эм, эмнэлгийн бүтээгдэхүүний үлдэгдэлтэй /ЭМЯ, Глобал сангийн дэмжлэгтэй ДОХ-ын төслийн нэгж 0.2 тэрбум төгрөг, ЭМЯ, Глобал сангийн дэмжлэгтэй Сүрьеэгийн төслийн нэгж 0.9 тэрбум төгрөг/;
- Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг хугацаанд нь байршуулдаггүй хугацаа хоцроосон;
- Үндэсний оношилгоо, эмчилгээний төв байгуулах төсөл он дамжиж ирсэн 1.2 тэрбум төгрөгийн татаас, санхүүжилтийн авлагыг бүрэн барагдуулаагүй бусдад өгөх өглөгөөр тайлагнасан;
- Уул уурхайн дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих төсөл эд хариуцагч солигдоход болон жилийн эцэст хөрөнгийн тооллого хийгээгүй, хөрөнгийг зохих зөвшөөрөлгүй өөр төсөлд ашиглуулсан, хадгалалт хамгаалалт, хяналт хангалтгүй;
- Боловсролын чанарын шинэчлэл төсөл батлагдсан төсвийн зардлыг 0.3 тэрбум төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан байна.

Засгийн газрын тусгай сангуудын санхүүгийн тайлангийн аудит

Засгийн газрын 22 тусгай сангаас 11 тусгай санд Төрийн аудитын байгууллага, 6 тусгай санд хараат бус аудитын хуулийн этгээд, 5 тусгай сан аудитын түүвэрт хамрагдсанаас Зөрчилгүй 9, Хязгаарлалттай 5 /Соёл урлагийг дэмжих сан, Эрүүл мэндийн даатгалын сан, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан, Боловсролын зээлийн сан, Тариалан эрхлэлтийг дэмжих сан/, Дүгнэлт өгөхөөс татгалзах 1 /Спортыг дэмжих сан/ дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 341.1 тэрбум төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 173.9 тэрбум төгрөгийн алдааг залруулж, 1.3 тэрбум төгрөгийн зөрчилд 7 төлбөрийн акт тогтоож, 118.4 тэрбум төгрөгийн зөрчлийг арилгах 14 албан шаардлага хүргүүлж, 47.5 тэрбум төгрөгийн алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх 52 зөвлөмж өгсөн байна.

Аудитын илрүүлэлт:

- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан: Жижиг зээл, санхүүгийн дэмжлэгээс 25.3 тэрбум төгрөгийн эргэн төлөлтийн хугацаа хэтэрсэн, татан буугдсан Капитал банктэй холбоотой 1.3 тэрбум, үүнээс ХХААХҮЯ авах зээлийн хугацаа хэтэрсэн 15.8 тэрбум төгрөгийн авлагын үлдэгдэлтэй;
- Боловсролын зээлийн сан: Өмнөх онуудад үүссэн 24.1 тэрбум төгрөгийн авлагын эзэн холбогдогч тодорхойгүй, дэлгэрэнгүй бүртгэл хөтлөөгүй, Засгийн газраас баталсан тэргүүлэх ач холбогдолтой мэргэжлийн чиглэлд багтаагүй мэргэжлээр бакалаврын хөтөлбөрийн 25 суралцагчдад 2.2 тэрбум төгрөгийн, үл хөдлөх хөрөнгийн барьцаагүйгээр 6 суралцагчид 0.4 тэрбум төгрөгийн зээл олгосон;
- Тариалан эрхлэлтийг дэмжих сан: Нийт авлагаас 2.1 тэрбум төгрөгийн авлага хугацаа хэтэрсэн, 39.8 тэрбум төгрөгийн авлагыг хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн, улаан буудайн үр

зээлээр худалдах, худалдан авах гэрээний үүргийн хэрэгжилт хангалтгүй, тариаланчдад олгосон дэмжлэгийн эргэн төлөлтийн орлогоос 0.1 тэрбум төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлээгүй;

- Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан: Монгол Улсын Хөгжлийн банкны төслөөс Үндэсний хөрөнгө оруулалтын банкаар дамжуулан олгосон зээлийн 2019 онд төлбөл зохих 0.2 тэрбум төгрөгийн үндсэн зээл болон зээлийн хүүг барагдуулаагүй;
- ЖДҮХС-аас 2009-2013 онд олгосон 32 иргэн, ААНБ-ын он дамжсан зээлийн авлага, 2014-2018 онд олгосон гэрээний хугацаа дуусаагүй боловч зээл, зээлийн хүүгийн төлөлт хийгдээгүй авлагыг тус тус барагдуулаагүй;
- Татан буугдсан Мал хамгаалах сангаас ЖДҮХС, Малын удмын сангийн үндэсний төвд шилжүүлсэн 31.5 тэрбум төгрөгийн авлагаас 6.7 тэрбум төгрөгийн авлага хугацаа хэтэрсэн, эзэн холбогдогчгүй авлага 31.1 тэрбум төгрөг;
- Спортыг дэмжих сан: Тайлант онд санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг дутуу ирүүлсэн, аудитад шаардлагатай баримт материалыг ирүүлээгүйгээс санхүүгийн тайлан үнэн зөв илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх боломжгүй тул санал дүгнэлт өгөхөөс татгалзсан.

Арван хоёр. САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧИЛ

Засгийн газрын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийх явцад санхүүгийн тайланд дараах залруулгыг хийлгэлээ. Үүнд:

- Аудитаар Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн байдлын тайланд төв төрийн сангийн 18.0 тэрбум төгрөгийн авлага, өглөгийн үлдэгдэл, үр дүнгийн тайланд давхардсан орлого, зардлын 176.4 тэрбум төгрөг;
- Төв төрийн сангийн санхүүгийн тайланд 0.5 тэрбум төгрөгийн өглөгийг тайлант оны бусад орлогоор, 0.2 тэрбум төгрөгийн өглөг, авлагыг хооронд нь хааж, ипотекийн зээлд олгосон 111.0 тэрбум төгрөгийн авлагыг нэмэгдүүлж, Засгийн газрын тогтоолоор хүчингүй болсон 49.4 тэрбум төгрөгийн өглөгийг бууруулж, ханшийн зөрүүгээр урт хугацаат хөрөнгө оруулалтыг 86.6 тэрбум, урт хугацаат зээл, үнэт цаасны өр төлбөрийг 319.7 тэрбум төгрөгөөр нэмж залруулга хийв.

Аудитаар нийт 1,483.0 тэрбум төгрөгийн 10 зөрчилд 4 албан шаардлага хүргүүлээ.

Арван гурав. ӨМНӨХ АУДИТААР ӨГСӨН ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

Засгийн газрын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар илэрсэн алдаа, зөрчлийг арилгуулахаар Ерөнхий сайдад 6, Сангийн сайдад 9, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт 2 зөвлөмжийг тус тус өгснөөс нийт 17 зөвлөмжийн хэрэгжилтийг хянаж, үнэлэхэд 73.6 хувийн биелэлттэй байна. Үүнд:

- Ерөнхий сайдад 6 зөвлөмж өгснөөс 1 зөвлөмж бүрэн хэрэгжиж, 5 зөвлөмж хэрэгжих шатандаа, татан буугдсан Капитал банканд байршиж байсан харилцах, хадгаламжийн данс, дамжуулан зээлийн үлдэгдлийг барагдуулж, улсыг хохиролгүй болгох арга хэмжээ авах зөвлөмж хэрэгжих шатандаа;
- Сангийн сайдад 9 зөвлөмж өгснөөс 4 зөвлөмж хэрэгжиж, 5 зөвлөмж хэрэгжих шатандаа;
- Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт өгсөн 2 зөвлөмж бүрэн хэрэгжээгүй.

Арван дөрөв. ДОТООД АУДИТ

Сангийн яамны Санхүүгийн хяналт, эрсдэлийн удирдлагын газар нь төсвийн ерөнхийлөн захирагчдын дотоод аудитын нэгжийг үйл ажиллагааны стандарт, арга зүйн удирдлагаар хангах, дотоод аудит, хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, чанарын баталгаажуулалт хийх, сургалт зохион байгуулах, хэрэглэгчийг зөвлөгөө, мэдээллээр хангах чиг үүргийг хэрэгжүүлж ажилласан байна.

Аймаг, нийслэл болон улсын ТЕЗ-дын дэргэдэх дотоод аудитын алба тайлант онд 949 байгууллагад санхүүгийн хяналт шалгалт хийж нийт 378.8 тэрбум төгрөгийн зөрчил илрүүлснээс 7.2 тэрбум төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 371.5 тэрбум төгрөгийн албан шаардлага, зөвлөмж өгсөн байна.



Дотоод аудитаар илэрсэн алдаа зөрчил өмнөх оноос буурахгүй байгаа нь төсвийн захирагчдын төсвийн сахилга бат, хариуцлага, дотоод хяналт сул, санхүүгийн ажилтнуудыг тогтвор суурьшилтай ажиллуулахгүй, мэргэшил, ур чадвар дутмаг байгаа зэрэг асуудлуудтай холбоотой байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчдын дотоод аудитын үйл ажиллагаанд тусгайлан аудит хийж үр дүнг үнэлэх шаардлагатай байна.

Арван тав. ДҮГНЭЛТИЙН ХЭЛБЭР, ҮНДЭСЛЭЛ

Бид Засгийн газрын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг баталгаажуулах аудитыг Аудитын олон улсын стандарт, Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.10.2-т заасны дагуу гүйцэтгэсэн.

Аудитын явцад хийсэн горим, сорилын үр дүнд санхүүгийн тайлангийн батламж мэдэгдлүүдтэй зөрчилдсөн материаллаг хэмжээний алдаа, зөрчилтэй дараах асуудлууд илэрсэн нь Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт 1705, Аудитын Олон улсын стандарт 705, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2018 оны А/124 дүгээр тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам”-ын 13.5-д заасны дагуу Засгийн газрын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд дараах үндэслэлээр “Хязгаарлалттай” дүгнэлт өгсөн болно. Үүнд:

- Зээл, тусламжаар хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрийн хүрээнд бий болсон 338.6 тэрбум төгрөгийн хөрөнгийг санхүүгийн тайланд тусгаагүй;
- Дампуурсан банк, Хадгаламж зээлийн хоршооноос авах 437.6 тэрбум төгрөгийн найдваргүй, дамжуулан зээлийн 593.3 тэрбум, Засгийн газрын тусгай сангуудын 138.6 тэрбум төгрөгийн эргэн төлөгдөх хугацаа хэтэрсэн авлагын үлдэгдэлтэй;
- Гадаад зээлийн 23 төсөл, хөтөлбөрийн эх үүсвэрээс дамжуулан зээлдүүлсэн 649.5 тэрбум төгрөгийн зээлийг 35 байгууллага санхүүгийн тайланд өглөгөөр бүртгээгүй зэрэг зөрчлүүд нь санхүүгийн тайлагналын оршин байх, үнэн зөв, эрх ба үүрэг, толилуулга ба тодруулга батламж мэдэгдлүүдтэй нийцэхгүй байна.

ДҮГНЭЛТ

1. Засгийн газрын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд өмнөх оны аудитын зөвлөмжийг хэрэгжүүлж төрийн болон орон нутгийн өмчийн 51-ээс дээш хувийн оролцоотой 13 хуулийн этгээдийн санхүүгийн тайланг нэгтгэсэн байна.
2. Эрсдэл үүсэж болзошгүй зарим арилжааны банкнуудад төрийн байгууллагуудын 317.8 тэрбум төгрөгийн мөнгөн хөрөнгө байршиж байна.
3. Дампуурсан банк, Хадгаламж зээлийн хоршооноос авах 437.6 тэрбум төгрөгийн найдваргүй, дамжуулан зээлийн 593.3 тэрбум, Засгийн газрын тусгай сангуудын 138.6 тэрбум төгрөгийн эргэн төлөгдөх хугацаа хэтэрсэн авлагын үлдэгдэлтэй байна.
4. Улс, орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн төсөл, арга хэмжээний үр дүнд бий болсон 1,735.0 тэрбум төгрөгийн хөрөнгийг ашиглагч байгууллагуудад шилжүүлээгүй, гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрийн хүрээнд бий болсон 338.6 тэрбум төгрөгийн хөрөнгийг санхүүгийн тайланд тусгаагүй, улсын комиссын акт гараагүй, тогтоол шийдвэргүй, санхүүжилт зогссон, өмчлөлийн маргаантай зэргээс шалтгаалан 117.0 тэрбум төгрөгийн барилга дуусаагүй барилга дансанд бүртгэлтэй байна.
5. Гадаад зээлийн эх үүсвэрээс дамжуулан зээлдүүлсэн 649.5 тэрбум төгрөгийн зээлийг 35 байгууллагын санхүүгийн тайланд өглөгөөр бүртгээгүй байна.

6. Гадаад зээлийн эх үүсвэрээс санхүүжсэн 226.3 тэрбум төгрөгийн 14 төсөлд эрсдэлийн үнэлгээ хийгээгүй, нийгэм эдийн засгийн ач холбогдлоор нь эрэмбэлээгүй байна.
7. Санхүүгийн нэгтгэсэн тайлангаарх 3,380.2 тэрбум төгрөгийн өр төлбөрийн өсөлтөд гадаад бонд, зээлийн өр ханшийн зөрүүгээс 662.2 тэрбум, гадаад зээлийн ашиглалтаар 1,638.6 тэрбум, төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой хуулийн этгээдийн өр төлбөр өмнөх оноос 1,532.3 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн нь нөлөөлсөн байна.
8. Монгол Улсын Хөгжлийн банк гадаад бонд, өөрийн хөрөнгийн эх үүсвэрээс 11 төрийн өмчит хуулийн этгээд, төсөл хөтөлбөрт олгосон 887.5 тэрбум төгрөгийн зээлийн үлдэгдлээс хугацаа хэтэрсэн 10.0 тэрбум, төсөл хөтөлбөрийн үйл ажиллагаа зогссоноос 79.2 тэрбум төгрөгийн зээлийн эргэн төлөлтөд эрсдэл үүссэн байна.
9. Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын Хувьцааг төрийн өмчид бүртгэж авах, холбогдох төлбөрийг суутган тооцох Засгийн газрын 2018 оны 7 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх арга хэмжээ аваагүй байна.
10. Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдүүдийн санхүүгийн тайланг удирдлагаар хангах, хяналт тавих эрх үүрэг бүхий төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгээгүй, үйл ажиллагааны салбараар нь хуваарилан нэгтгэж байгаа нь оновчтой бус, харьяалуулах талаар шийдвэр гаргаагүй байна.
11. Сангийн сайдын 2006 оны 388, 2007 оны 326 дугаар тушаалаар баталсан төсөвт байгууллага болон төсөл, хөтөлбөрийн нэгж, Засгийн газрын тусгай санд мөрдөх дансны заавар, төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой хуулийн этгээдийн санхүүгийн тайланг нэгдсэн дансны ангилал, аргачлал нь УСНББОУС болон СТОУС-тай нийцэхгүй байна.

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

УЛСЫН ИХ ХУРАЛД ТОЛИЛУУЛАХ НЬ:

1. Монголбанкнаас арилжааны банкнуудад хийсэн эрсдэлийн үнэлгээ, хяналт шинжилгээний дүнд үндэслэн төрийн мөнгөн хөрөнгийг эрсдэлээс хамгаалах бодлого боловсруулах үүргийг холбогдох байгууллагад өгч, хэрэгжилтийг хангуулахыг уламжилж байна.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙДАД:

1. Засгийн газрын 2018 оны 7 дугаар тогтоолоор хувьцааг төрийн өмчид бүртгэж авах, холбогдох төлбөрийг суутган тооцох тухай асуудлыг судалж, шийдвэрлэх
2. Төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой хуулийн этгээдийн санхүүгийн тайланд олон жил бүртгэлтэй дуусаагүй барилгын асуудлыг шийдвэрлэх, татан буугдсан хуулийн этгээдийн хөрөнгийг шилжүүлж, үндсэн хөрөнгийн хөдлөлийн бүртгэлийг цахимжуулах.
3. Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдүүдийн санхүүгийн тайланг хяналт хэрэгжүүлэгч төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяалуулах асуудлыг судалж, шийдвэрлэх.

САНГИЙН САЙДАД:

1. Гадаадын зээл, тусламжийн хөрөнгийг хөгжлийн бодлого, зорилттой уялдуулж эдийн засаг, нийгмийн үр ашигтай төсөлд зарцуулж, үр өгөөжийг нэмэгдүүлэх, үр ашиггүй, хуулийн шаардлага хангахгүй, эрсдэлийн үнэлгээ хийгээгүй төсөл, хөтөлбөрт төсөв хуваарилахгүй байх, төсөвт өртгийг бодитой тооцох, барьж байгуулсан хөрөнгийн ашиглалт, хамгаалалт, хяналтыг сайжруулах.
2. Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдэж байгаа төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой хуулийн этгээдийн санхүүгийн



тайлангийн эдийн засгийн ангиллыг УСНББОУС болон СТОУС-тай нийцүүлэн дансны нэгдсэн жагсаалтыг шинэчлэн боловсруулах.

3. Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”, 2007 оны 326 дугаар тушаалаар баталсан “Засгийн газрын шугамаар авч, ашиглаж буй хөнгөлөлттэй зээл болон буцалтгүй тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөр, засгийн газрын тусгай санд мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ыг шинэчлэгдсэн стандартад нийцүүлэх.
4. Төсвийн тухай хуулийн 8.9.8, 54.2 дахь заалтуудыг үндэслэн төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой хуулийн этгээдийн санхүүгийн тайланг төсвийн ерөнхийлөн захирагчдын санхүүгийн тайланд УСНББОУС болон СТОУС-ын дагуу нэгтгэх аргачлалыг боловсруулах.



МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОРЫН
ТУШААЛ

2020 оны 06 сарын 10 өдөр

Дугаар А/51

Улаанбаатар хот

┌Аудитын тайланг баталгаажуулах тухай ┐


Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 29 дүгээр зүйлийн 29.1.9, 33 дугаар зүйлийн 33.5 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.10.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Монгол Улсын Засгийн газрын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын тайлан”-г нэгдүгээр хавсралтаар, аудитаар өгсөн албан шаардлагыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталгаажуулсугай.

2. Аудитын тайланг Монгол Улсын Их Хурал, Засгийн газар, Сангийн яаманд тус тус хүргүүлсүгэй.

3. Аудитаар хүргүүлсэн албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, биелэлтийг 2020 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Монгол Улсын Ерөнхий сайд, Сангийн сайдад тус тус зөвлөсүгэй.


4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллахыг Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч бөгөөд тэргүүлэх аудитор /О.Тэнгис/-т үүрэг болгосугай.



Д.ЗАНДАНБАТ



Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны 06 сарын 10-ны өдрийн А/51 дугаар тушаалын 2 дугаар хавсралт



ЗАСГИЙН ГАЗРЫН 2019 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТААР ӨГСӨН АЛБАН ШААРДЛАГЫН ЖАГСААЛТ

Д/д	Хариуцагч байгууллага	Албан шаардлага		Зөрчлийн товч утга	Зөрчлийн дүн /тэрбум төгрөгөөр/
		Огноо	Өгсөн албан тушаалтан		
1	Өмнөговь аймаг дахь Таван толгой ХК	2020.06.09	Аудитор Л.Мөнхцацрал	Орон нутгийн өмчит Таван толгой ХК нь эрх бүхий этгээдийн шийдвэргүйгээр Хадгаламж зээлийн хоршоонд 2.0 тэрбум төгрөгийн мөнгөн хадгаламж байршуулсан.	2.0
2	Сангийн яамны Төрийн сангийн газар, Санхүүгийн бодлогын газар	2020.06.09	Аудитор А.Даваадорж, Д.Болор-Эрдэнэ	Валютын ханшийн зөрүүгээс үүссэн 24.1 тэрбум төгрөгийг санхүүгийн тайланд авлагаар бүртгэсэн	24.1
				Дампуурсан банк, Хадгаламж зээлийн хоршоо, эрх хүлээн авагчаас авах 437.6 тэрбум, 1991-1996 онуудад 92 хувийн хэвшлийн байгууллагад олгосон 302.6 тэрбум төгрөгийн олон жилийн насжилттай, дамжуулан зээлийн найдваргүй авлага байна.	740.2
3	Сангийн яамны Төрийн сангийн газар, Санхүүгийн бодлогын газар	2020.06.09	Аудитор А.Даваадорж, Д.Болор-Эрдэнэ	Төв төрийн сангийн санхүүгийн тайланд олон жил болсон хөрөнгө оруулалтын санхүүжилтын урьдчилгаа 65.0 тэрбум төгрөгийг шийдвэрлээгүй.	65.0
4	Сангийн яамны Төрийн сангийн газар, Санхүүгийн бодлогын газар, Хөгжлийн санхүүжилтийн газар	2020.06.09	Ахлах аудитор Р.Цолмон, Аудитор П.Амарсанаа	Гадаадын зээлийн хөрөнгийг дотоодод дамжуулан зээлдүүлэх журам Өрийн удирдлагын тухай хуультай уялдаагүй	
				Шүүхийн шийдвэрээр хэрэгсэхгүй болгосон 2.2 тэрбум төгрөгийг авлагыг данс бүртгэлээс хасаагүй	2.2
				Дамжуулан зээлийн 649.5 тэрбум төгрөгийн өглөг 35 байгууллага санхүүгийн тайланд бүртгээгүй	649.5
	Дүн				1,483.0